



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/485

Улаанбаатар хот

Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Онцгой байдлын байгууллагын “Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм”-ийг нэгдүгээр, Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн бүртгэлийг хоёрдугаар, Амьсгалын бие даасан төхөөрөмжийн техникийн бүртгэлийг гуравдугаар, Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн ажиллагаа тооцох хуудсыг дөрөвдүгээр, Амьсгалын бие даасан төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийн хөтлөх хүснэгтийг тавдугаар, Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажилласан бүртгэлийг зургаадугаар, Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг, төвийн байранд байх багаж, хэрэгслийн жагсаалтыг долоодугаар, Шахсан агаарын амьсгалын бие даасан төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг наймдугаар, Тусгаарлагч шүүгч амьсгалын бие даасан төхөөрөмжийн шингээгч, шүүгч шохойн техникийн үзүүлэлтийг есдүгээр, Хүйтний улиралд тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах хугацааг аравдугаар, Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг арван нэгдүгээр, Битүүмжлэл шалгах төхөөрөмжөөр тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг шалгасан тухай бүртгэлийн хуудсыг арван хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан дүрэм, баримт бичгийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (бригадын генерал Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.


4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/134 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/1 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт
1485



АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилго нь Онцгой байдлын байгууллагын алба хаагч сургалт, дадлага, гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, албаны бэлэн байдлыг хангахад оршино.

2. Энэхүү дүрмийг “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гал түймэр унтраах дүрэм, Аврах ажиллагааны журам, Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод аврах ажиллагааг зохион байгуулах журам, амьсгалын бие даасан төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар, үндэсний болон олон Улсын стандартад нийцүүлэн боловсруулав.

3. Онцгой байдлын байгууллагын бүсийн төвүүд, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Нийслэл, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар болон гал түймэр унтраах, эрэн хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдад хамаарна.

4. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүний эрүүл мэндэд аюултай хортой хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй аюулт үзэгдэл, осол, бүх төрлийн гал түймрийн голомтод ажиллах, дадлага сургалт зохион байгуулах үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй (АБДТ) албан хаагчдыг ажиллуулна.


5. Амьсгалын бие даасан төхөөрөмж гэдэг нь шахсан агаарын тусгаарлах төхөөрөмж болон хүчилтөрөгчийн шүүгч төхөөрөмжийг нэрлэх ба гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед төхөөрөмж эзэмшигчийн амьсгалын эрхтэн, нүдний харааг хамгаалж, амьсгалах боломжгүй болон хортой утаа, аюултай хийтэй орчинд ажиллах боломжийг олгоно.

6. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэдэг амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмших эрх бүхий Онцгой байдлын албан хаагч (цаашид АБДТ эзэмшигч гэх) нэг бүр амьсгалын бие даасан төхөөрөмжөөр хангагдсан байна.

7. Амьсгалын бие даасан төхөөрөмж эсвэл түүний нүүр хамгаалах багийг албан хаагч нэг бүрд бүртгэлээр хариуцуулна.

8. Амьсгалын бие даасан төхөөрөмж нь Онцгой байдлын байгууллагын өмч бөгөөд төхөөрөмж эзэмшигч нь дүрмийн дагуу бүрэн бүтэн байдлыг ханган ашиглах үүрэгтэй.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
А/1 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт
1485



АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ҮЕД ДАГАЖ МӨРДӨХ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилго нь Онцгой байдлын байгууллагын алба хаагч сургалт, дадлага, гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, албаны бэлэн байдлыг хангахад оршино.

2. Энэхүү дүрмийг “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Гал түймэр унтраах дүрэм, Аврах ажиллагааны журам, Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод аврах ажиллагааг зохион байгуулах журам, амьсгалын бие даасан төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн ашиглалтын заавар, үндэсний болон олон Улсын стандартад нийцүүлэн боловсруулав.

3. Онцгой байдлын байгууллагын бүсийн төвүүд, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Нийслэл, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар болон гал түймэр унтраах, эрэн хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдад хамаарна.

4. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүний эрүүл мэндэд аюултай хортой хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй аюулт үзэгдэл, осол, бүх төрлийн гал түймрийн голомтод ажиллах, дадлага сургалт зохион байгуулах үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй (АБДТ) албан хаагчдыг ажиллуулна.

5. Амьсгалын бие даасан төхөөрөмж гэдэг нь шахсан агаарын тусгаарлах төхөөрөмж болон хүчилтөрөгчийн шүүгч төхөөрөмжийг нэрлэх ба гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед төхөөрөмж эзэмшигчийн амьсгалын эрхтэн, нүдний харааг хамгаалж, амьсгалах боломжгүй болон хортой утаа, аюултай хийтэй орчинд ажиллах боломжийг олгоно.

6. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэдэг амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмших эрх бүхий Онцгой байдлын албан хаагч (цаашид АБДТ эзэмшигч гэх) нэг бүр амьсгалын бие даасан төхөөрөмжөөр хангагдсан байна.

7. Амьсгалын бие даасан төхөөрөмж эсвэл түүний нүүр хамгаалах багийг албан хаагч нэг бүрд бүртгэлээр хариуцуулна.

8. Амьсгалын бие даасан төхөөрөмж нь Онцгой байдлын байгууллагын өмч бөгөөд төхөөрөмж эзэмшигч нь дүрмийн дагуу бүрэн бүтэн байдлыг ханган ашиглах үүрэгтэй.


9. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах албан хаагч нь объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмссөн байна.

10. Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, нийслэлийн Онцгой байдлын газар, Бүсийн төвүүд, орон нутгийн Онцгой байдлын газрууд амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төвтэй байна.

11. Гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, салбар, бүлгүүд амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг байна.

12. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага сургалтыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах зорилгоор, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, бүсийн төвүүд, Онцгой байдлын газар, хэлтэс, Гал түймэр унтраах, аврах анги, салбарууд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах дадлага, сургалтын тусгай тоноглол бүхий талбай, утаатай болон давчуу орчинд ажиллах сургалтын байгууламжтай байна.

13. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах нэгдсэн дадлага, сургалтыг Бүсийн төвүүд, Онцгой байдлын газар, хэлтэс, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагч нар хагас жилд нэгээс доошгүй удаа, анги, салбарын дарга, захирагч нар улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулсан байна.



Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчид тавигдах шаардлага

14. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагчид анхан шатны буюу давтан сургалтад батлагдсан хөтөлбөрийн дагуу жилд 1 удаа заавал хамрагдана. Сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн алба хаагчийг амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллахыг зөвшөөрнө. Үүнд:

- 14.1. Эмнэлгийн дүгнэлтээр зөвшөөрсөн байх.
- 14.2. Онолын мэдлэгийн шалгалтад тэнцсэн байх.
- 14.3. Дадлага ажлын шалгалтад тэнцсэн байх.

15. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч алба хаагчид жил бүр хоёроос доошгүй удаа эрүүл мэндийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдан, эмнэлгийн дүгнэлт гаргуулж, амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн хувийн карт дээр тэмдэглэж баталгаажуулсан байна. Үүнд:

- 15.1. Сүрьеэ
- 15.2. Мэдрэл
- 15.3. Дотор

15.4. Гэмтэл

15.5. Чих, хамар, хоолой

15.6. Нүд

15.7. Арьс харшил

16. Анхан шатны болон давтан сургалт, шалгалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд: Онолын мэдлэг

16.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүтэц, ажиллагааны зарчим;

16.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үеийн ерөнхий үзүүлэлтийг тооцох;

16.3. Дадлага ажил:

16.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн шалгалтууд;

16.5. Эвдрэл, доголдлыг таних, урьдчилан сэргийлэх;

16.6. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үеийн харилцаа, холбоо;

16.7. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг өмсөх, агаараар хангах хавхлагын системд холбох, тайлах

17. Сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцээгүй болон эмнэлгийн дүгнэлтээр амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшихээр зөвшөөрөгдөөгүй албан хаагч нарт амьсгалын бие даасан төхөөрөмж олгох, эзэмшүүлэхийг хориглоно.

18. Шалгалтад тэнцээгүй алба хаагчийг шалгалт өгсөн өдрөөс хойш 1 сарын хугацаанд давтан сургалтад хамруулж дахин шалгалт өгүүлнэ.

19. Томилгоот ээлжинд тогтмол гардаггүй боловч амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагчид анхан шатны болон давтан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх ба улирал тутам нэгээс доошгүй удаа тусгай тоноглол бүхий талбайд болон ердийн орчинд 3-аас доошгүй цагийн дадлага, сургалт заавал хийсэн байна.

20. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх Үндэсний аврах бригад, Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, Уул уурхайн аврах анги, эрэн хайх аврах анги, салбаруудын албан хаагчдыг удирдан ажиллах даргалах бүрэлдэхүүн хагас жилд нэг удаа тусгай тоноглол бүхий талбайд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй 3-аас доошгүй цагийн дадлага, сургалтад хамрагдана.

21. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч алба хаагчийн анхан шатны болон давтан сургалтад хамруулж, шалгалт авах ажлыг Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, Эрэн хайх аврах анги, салбарын захирагч нар хариуцан зохион байгуулна.

22. Шалгалтад тэнцсэн алба хаагчид шинээр төхөөрөмж олгохдоо алба хаагч бүрт тохиролын шалгалт (Fit test)-ыг Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, Эрэн хайх аврах анги, салбарын захирагчийн удирдлага дор амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин хийж гүйцэтгэнэ. Тохиролын шалгалтыг амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн жин их хэмжээгээр өөрчлөгдөх, нүүрний хэлбэрт нөлөөлөхүйц мэс засалд орсны дараа дахин хийж гүйцэтгэнэ.

23. Тохирлын шалгалтаар дараах зүйлийг шалгана. Үүнд:

23.1. Төхөөрөмж эзэмшигчид нүүр хамгаалах баг нь нүүрний хэлбэрт зөв таарсан эсэх,

23.2. Дуулга малгай, дотуур малгай (подкаска), нүүр хамгаалах багийн өмсгөл хоорондын харьцаа таарсан эсэх,

23.3. Төхөөрөмжтэй ажиллаж хөдөлгөөн хийх үед нүүр хамгаалах багад зай, завсар үүсэж агаарын алдагдал гарч байгаа эсэхийг шалгана.

24. Тохирлын шалгалтыг чанарын аргаар буюу амт, үнэр, эсвэл утаа зэрэг туршилтын бодис ашиглаж, хэрэглэгч төхөөрөмжтэй ажиллах үед нүүр хамгаалах багаас ямар нэгэн зүйл мэдэрч байгаа эсэхийг шалгана.

25. Шаардлагатай тохиолдолд тоон аргаар буюу нүүр хамгаалах багийг битүүмжлэл шалгах төхөөрөмжид оруулж шалгана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шахсан агаарын амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн зохион байгуулалт

26. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүний эрүүл мэндэд хортой хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй амьсгалахад хүндрэлтэй орчинд ажиллах анхны нэгж нь амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг байна.

27. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь дараах бүтэц зохион байгуулалттай байна. Үүнд:

27.1. Голомтод ажиллах хэсэг.

27.2. Аюулгүй байдлыг хангах хэсэг.

27.3. Шалган зааварлах хэсэг.

28. Голомтод ажиллах хэсгийн бүрэлдэхүүн нь хэсгийн ахлагчийг оролцуулан нэг төрлийн төхөөрөмжтэйгээр хамгийн багадаа гурав болон таван албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулна.

29. Ажиллагааны удирдагчийн шийдвэрээр хэсгийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх шаардлагатай бол дараагийн хэсгийг зохион байгуулна.

30. Голомтод ажиллах хэсгийн бүрэлдэхүүнийг гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах ажиллагаанд биечлэн оролцдог нэг салаа, бүлгийн албан хаагчдаас бүрдүүлэн шаардлагатай тохиолдолд өөр салаа, бүлгийн аврагч, гал сөнөөгчдийг гал түймэр унтраах удирдагч, ажиллагааны удирдагчийн шийдвэрээр оролцуулж болно.

31. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллаж байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийг дараах албан тушаалтан удирдан ажиллуулна. Үүнд:

31.1. Нэг тасаг, бүлэг ажиллаж байгаа үед голомтод ажиллах хэсгийн даргаар салааны захирагч, бүлгийн дарга, түүний шийдвэрээр томилогдсон туршлагатай гал сөнөөгч, аврагч.

31.2. Хэд хэдэн тасаг, бүлэг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллах үед эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн тушаалаар томилогдсон албан хаагч.

31.3. Ажиллагааны удирдагч нь өөрөө голомтод орж ажиллавал уг албан тушаалтан.

32. Голомтод ажиллах хэсгийн бүрэлдэхүүн нь нэмэлт салаалагч бүхий амьсгалын бие даасан төхөөрөмж эсвэл нөөц бортоготой ажиллана.

33. Голомтод ажиллах хэсгийн албан хаагчдаас хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд хэсэг яаралтай цэвэр агаарт гарах ажиллагааг эхлүүлэх, анхны тусламж үзүүлэх, шаардлагатай бол эмчийн хяналтад өгч, аюулгүй байдлыг хангах хэсэг, шалган зааварлах хэсэгт болсон асуудлын талаар мэдэгдэнэ.

34. Голомтод ажиллаж байгаа хэсэг нь бүрэн бүрэлдэхүүнээрээ голомтоос гарах ба ямар нэгэн шалтгаанаар албан хаагч үлдээхийг хориглоно.

35. Голомтод ажиллах хэсэг утаатай орчинд хайгуул хийхдээ дараах багаж хэрэгслийг авч явна. Үүнд:

35.1. Аврах олс.

35.2. Гэрэлтүүлэх хэрэгсэл.

35.3. Холбооны хэрэгсэл.

35.4. Задаргаа хийх гар багаж.

35.5. Хушуу, хоолой (Гал унтраах удирдагчийн шийдвэрээр)

35.6. Дулаан мэдрэгч камер.

35.7. Агаар дахь хүчилтөрөгч, шатамхай хийг тодорхойлох багаж.

35.8. Хувийн дохиолол (Хөдөлгөөн мэдрэгч)

35.9. Олон ажиллагаатай аврах гогцоо

35.10. Цахилгааны хүчдэл тодорхойлох багаж

35.11. Нэрвэгдэгчийг аврах нөөц нүүрэвч баг

Аюулгүй байдлыг хангах хэсэг

36. Аюулгүй байдлыг хангах хэсэг нь голомтод ажиллах албан хаагчдын аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

37. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллаж байгаа үед ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах шуурхай штабын дарга, шалган зааварлах хэсгийн дарга нар, дадлага, сургалтын үед сургалтын удирдагч нар аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийг тухайн үеийн цагийн байдалтай уялдуулан томилж ажиллуулна.

38. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн цагийн байдал хүндэрсэн үед нэмэлт ажиллагаанд оролцох, голомтод ажиллах хэд, хэдэн тасаг, бүлгийг зохион байгуулж бэлэн байдлыг хангана.

39. Голомтод ажиллах хэсгийн алба хаагчдын бортогоны даралтын ажиллах хугацааг урьдчилан тооцох, зарцуулалтыг алсаас хянах, хэсгийн даргад мэдээлэл өгөх, орох, гарах дохио өгөх, ажилласан цаг хугацааны бүртгэл хөтлөх.

40. Нэмэлт ажиллагаанд оролцох хэсгийн албан хаагчдын бортого дахь агаарын даралт 80 хувиас доошгүй байна.

Шалган зааварлах хэсэг

41. Удаан хугацаагаар үргэлжилсэн гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хэд хэдэн хэсгүүд ажиллаж байвал ажиллагааны дарга нар нь шалган зааварлах хэсгийг зохион байгуулна.

42. Ажиллагааны удирдагч нь шалган зааварлах хэсгийн даргаар офицер, туршлагатай албан хаагчийг томилно. Шалган зааварлах хэсгийн даргын удирдлагад хүрэлцэхүйц тооны албан хаагчдыг томилон ажиллуулах ба хэсгийн бүрэлдэхүүнд эмч ажиллуулна.

43. Шалган зааварлах хэсгийн дарга, гал түймэр унтраах удирдагч болон эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч нар ажиллагааг удирдах штаб, гал түймэр унтраах шуурхай штаб зохион байгуулагдсан бол штабын даргад шууд захирагдана. Штабын даргын тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгүүдийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллана.

44. Шалган зааварлах хэсгээс нэмэлтээр амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн алба хаагчдад мэдээлэл өгөх болон хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрдлийг хангуулна.

45. Шалган зааварлах хэсгийн байранд дараах зүйлс зайлшгүй байвал зохино. Үүнд:

45.1. Таваас доошгүй нөөц амьсгалын бие даасан төхөөрөмж.

45.2. Бортого, бусад сэлбэгийн нөөц.

45.3. Агаараар цэнэглэх шахуурга (зөөврийн)

45.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг шалгах тусгай зориулалтын хэрэгсэл.

45.5. Иж бүрэн тусгай түлхүүр, багаж.

45.6. Халуун цай, аарц, чацарганы шүүс.

45.7. Анхны тусламжийн иж бүрдэл.

45.8. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн арчилгаа үйлчилгээний бодис, материал (цэвэрлэх, ариутгах, тослох, үл цантуулагч бодис)

45.9. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн нөөц

46. Цаг агаарын болон хүндрэлтэй нөхцөлд ажилласан бие бүрэлдэхүүний бие, эрүүл мэндийн байдалд өөрчлөлт орохоос урьдчилан сэргийлж, шалган зааварлах хэсгийн дарга нь тусгаарлах өрөө буюу байр бэлтгэж байрлуулна.

Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэг

47. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, турших, шалгах, засвар үйлчилгээ хийх ажлыг засвар үйлчилгээний төв, засварын хэсэг хариуцан хийх ба түүнд тухайн нэгжийн удирдлага хяналт тавина.

48. Засвар үйлчилгээний төв нь амьсгалын бие даасан төхөөрөмж түүний бүрдлийг туршин шалгах, эд анги бүрээр задалж цэвэрлэх, ариутгах, эд анги солих зэрэг засах, эд ангийн тосолгоо хийж ашиглаж болох эсэх талаар дүгнэлт гаргана.

49. Засварын хэсэг нь тухайн нэгжийн хэмжээнд байгаа АБДТ-ын бэлэн байдлыг хангах, ажиллагаа, аюулгүй байдал, цэвэрлэгээ, эрүүл ахуйг шалгах, холбогдох засвар, үйлчилгээ хийх, тослох, ариутгах, ажиллагааг хийж баримт бичгийг хөтлөх, баяжилт хийх, засвар үйлчилгээний төвд шилжүүлэх саналыг гаргана.

50. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төвд ахлах засварчин, засварын хэсэгт засварчин ажиллана.

51. Бортого цэнэглэх өрөөнд агаараар цэнэглэх шахуургын ашиглалтын сургалтад хамрагдсан албан хаагч, засварчнаас өөр хүн орохыг хатуу хориглоно.

52. Нүүр хамгаалах багийг ариутгах уусмалд (30°C) 15 минут, хатаах өрөөний агаарын дулааны хэмжээ +3°C-аас +25°C, дээд хэмжээ +60°C нарны шууд тусгалаас хол, дулааны үйлчлэлээс хамгаалах шаардлагатай.

53. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төвийн өрөө тасалгаанууд агаарын стандартын шаардлага хангасан байх ба засвар үйлчилгээний төв, хэсгийн өрөө тасалгааны аюулгүй ажиллагааны журам боловсруулан батлуулж, мөрдлөг болгон ажиллах.

54. Бортого цэнэглэх өрөө 16 м²–аас багагүй, агааржуулалтын системд холбогдсон байна. Цэнэгтэй бортогыг нарны шууд тусгал, дулааны үйлчлэлээс хол, тоос шороо чийгнээс хамгаална. Цэвэрлэх, ариутгах өрөө нь угаалтуур, хатаагч шүүгээ зэргээс бүрдэл болно.

55. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсгийн байранд байх тоног төхөөрөмж, эд хөрөнгийг зургаадугаар хавсралтад заасны дагуу бүрдүүлэн байрлуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалтын талаар албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс,

Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах ангийн дарга, захирагчийн үүрэг

56. Бүсийн төв, Онцгой байдлын газар, хэлтэс, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах ангийн дарга нар амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагч нэг бүрийг эмнэлгийн үзлэгт хамруулах шууд хариуцан зохион байгуулна.

57. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, хэсгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, цэвэрлэгээ, ариутгал, тосолгоо, үл цантуулах тусгай бодис материалын нөхөн хангалтын асуудлыг шууд хариуцна.

58. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах анхан шатны болон давтан сургалт, амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалтын засвар үйлчилгээний төвийг бэхжүүлэх талаар шаардагдах зардлыг төсөвт тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

59. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдын амьсгалын бие даасан төхөөрөмжийн аюулгүй байдал, эрсдэлийг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавина.

60. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хүндрүүлсэн нөхцөлд ажиллах дадлага, сургалтын тусгай тоноглол бүхий талбайтайг тохижуулан бэлтгэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан мэргэжилтний үүрэг

61. Бие бүрэлдэхүүний амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах талаар шат дараалсан сургалт, засвар үйлчилгээний төв, хэсэг, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл шалгах хэсгийн үйл ажиллагаа, 4 төрлийн шалгалтын явц, бүртгэл, баталгаажуулалтад 6 дугаар бүлэгт заасан хугацааны дагуу хяналт тавих.

62. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч албан хаагчдыг утаатай, үзэгдэх орчин хязгаарлагдмал, биеийн хүч шаардсан, хүндрүүлсэн нөхцөлд бэлтгэн дадлагажуулах, гал сөнөөгч, аврагчдын нэгдсэн цугларалтын үед анхан шатны болон давтан сургалтыг явуулахад мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх.

63. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэх, сургалт дадлагын явцад холбогдох дүрмүүдийн заалт болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хяналт тавих.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтний үүрэг

64. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулж, хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавина.

65. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах, ашиглах, засвар үйлчилгээ хийх үеийн аюул эрсдэлийн үнэлгээг зохих журмын дагуу хийж, бууруулах арга хэмжээг боловсруулан хэрэгжилтэд хяналт тавих.

66. Засвар үйлчилгээний төв, засварын хэсэг, сургалт дадлагын талбай бүхий орчинд хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг хангуулж, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны дэглэмийг мөрдүүлэх.

67. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалт, сургалт, дадлагын явцад гарч болзошгүй осол, гэмтлийн шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ санал болгож, удирдлагад танилцуулан хэрэгжилтэд хяналт тавих.

68. Томоохон гамшиг, осол, гал түймрийн үед амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын аюулгүй байдлыг хянан, хамгаалах хувцас, хэрэгсэл, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, шаардлагатай тохиолдолд шуурхай зөвлөмж өгөх.

69. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн төв, хэсгийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, дүрэм, стандартын хэрэгжилтийг үнэлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг өгөх, биелэлтэд хяналт тавих.

70. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг амьсгалын бие даасан төхөөрөмжийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах, зааварчилгаа өгөх, үнэлгээ хийх.

Гал түймэр унтраах аврах анги, Аврах ангийн захирагчийн үүрэг

71. Гал түймэр унтраах аврах анги, Аврах ангийн захирагч нь хариуцсан ангийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн бэлэн байдал, бүрэлдэхүүний дадлага, сургалтын ажлыг шууд хариуцна.

72. Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний бүрдэл хэсэг бортогоны хадгалалт, тээвэрлэлтийн болон цэнэглэх үеийн аюулгүй байдлыг хангуулах.

73. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, хэсгийн үйл ажиллагааг удирдах, хянах.

Салааны захирагч, бүлгийн дарга захирагчийн үүрэг

74. Салаа, бүлгийн бүрэлдэхүүнийг сургалт, дадлагын батлагдсан хөтөлбөрийн дагуу сургаж, дадлагажуулах.

75. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн шалгалтуудыг тогтоосон хугацаанд зааврын дагуу хийлгэж, засварт орох төхөөрөмжийг засвар үйлчилгээний төв, засварын хэсэгт өгч шалгуулах.

76. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэсний дараа хийх шалгалт, үйлчилгээг энэ дүрэм болон амьсгалын бие даасан төхөөрөмжийн үйлдвэрээс тогтоосон заавар, зөвлөмжийн зааврын дагуу хийх.

77. Нөөцөнд байгаа бортого, гал түймэр унтраах автомашины болон засварын хэсэгт байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах.

78. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүнийг зохион байгуулж аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчны үүрэг

79. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин нь амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах анги, Гал түймэр унтраах аврах ангийн захирагч, аврах ажиллагаа, гал түймэр унтраах үед эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, шалган зааварлах хэсгийн даргад захирагдана. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин нь дараах үүргийг хариуцан гүйцэтгэнэ. Үүнд:

79.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн төрөл бүтэц, үйлчилгээ, шалгалт хийх журам, төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрмийг мэргэжлийн өндөр түвшинд бүрэн эзэмшиж мэдсэн байна.

79.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засвар үйлчилгээний төв, засварын хэсэгт байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүчин чадлын дагуу бүрэн дүүрэн хэрэглэж чаддаг байх.

79.3. Засвар үйлчилгээний төв, хэсгийг энэ дүрэмд заасны дагуу зохион байгуулах.

79.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалт, хадгалалтад тогтмол хяналт тавьж, өөрийн харьяалалд байгаа Үндэсний аврах бригад, Уул уурхай аврах анги, Гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, салбарын амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчдийг сургах, дадлагажуулах ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллах.

79.5. Амьсгалын бие даасан төхөөрөмжид жилд нэг удаа бүрэн засвар, үйлчилгээ хийж бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах.

79.6. Засвар үйлчилгээний төв, хэсгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн бүтэн байлгаж, хэрэглэх үед аюулгүй ажиллагааны шаардлагыг сахиулж, амьсгалын бие даасан төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бүртгэлийн баримт бичгийг үнэн зөв баталгаажуулан хөтлөх.

79.7. Бортогони нөөцийг бэлтгэх, шаардлагатай бол турших, шалгуулахаар шинжилгээнд явуулж дүгнэлт гаргуулах, бэлэн байдлын хуваарьт ашигласан бортогыг 5 жилд нэг удаа стандартын шаардлага хангасан эсэхийг туршиж иж бүрэн шалгалтанд оруулах.

79.8. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн гуравдугаар шалгалт хийх жилийн график төлөвлөгөөний хуваарийг гаргах, шалгалт хийх, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагаатай эсэхийг улирал бүр шалган энэ тухай техникийн-үзлэгийн тэмдэглэл хөтлөн, материалжуулах.

79.9. Томоохон хэмжээний гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод ажиллах үед шаардлагатай тооны агаар хадгалах цэнэгтэй сав, амьсгалын бие даасан төхөөрөмжийг төвлөрүүлэн ажиллах.

79.10. Жил бүр агаарын шахуурга, амьсгалын бие даасан төхөөрөмжийн хэвийн байдлыг шалгаж үнэлгээ дүгнэлт өгч техникийн үзлэгийн тэмдэглэл хөтлөн, удирдах албан тушаалтанд танилцуулах, шийдвэрлүүлэх.

Шалган зааварлах хэсгийн даргын үүрэг

80. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аврах болон гал түймэр унтраах ажиллагааг зохион байгуулах талаар авралтын ажиллагааны дарга, гал түймэр унтраах удирдагчийн өгсөн үүрэг, тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулан мэргэжлийн болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх.

81. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд ажиллаж байгаа хэсгүүдийг тогтоосон хугацаанд нь солих ажиллагааг хангахын дээр ажиллаж, амарч байгаа болон бэлтгэлд байгаа хэсгүүдийн тооцоог гуравдугаар хавсралтын дагуу бүртгэх.

82. Аюулгүй байдлыг хангах хэсгүүд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэгтэйгээ байнгын холбоотой ажиллаж байгааг шалгаж, хэсгүүдийн амралтыг зохион байгуулах, хэсгүүдийн ажиллагааны талаар авралтын ажиллагааны дарга, гал түймэр унтраах удирдагчид байнга илтгэх.

83. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг, бортого, бусад сэлбэг, хэрэгслийн нөөцийг бий болгох.

84. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хүрэлцэн ирсэн эмнэлгийн яаралтай тусламж, эмчийн тусламжтайгаар амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэг болон бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдалд хяналт тавьж ажиллах.

Аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийн үүрэг

85. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүний хувийн зэвсэглэмж, бусад багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих.

86. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсгийн бүрэлдэхүүнтэй байнга холбоотой ажиллана. Хэрэв холбоо тогтоох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд хариуцсан даргадаа яаралтай мэдэгдэж, удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

87. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, хичээл зааж буй сургагч нартай тогтмол холбоотой байх бөгөөд холбооны хэрэгсэлгүй үед холбоочинтой ажиллах.

88. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хорт хий, утаа ялгарсан, ялгарч болзошгүй, амьсгалахад хүндрэлтэй орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжгүй буюу төхөөрөмжтэй боловч тухайн хэсгийн бүрэлдэхүүнд ороогүй албан хаагчдыг болон гадны хүнийг нэвтрүүлэхгүй байх.

89. Шалган зааварлах хэсгээс гаргасан амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах тооцооны дагуу голомтоос буцах дохиог амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа хэсэгт дамжуулах ба төхөөрөмжтэй ажилласан тооцооны бүртгэлийг хөтлөх.

Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн ахлагчийн үүрэг

90. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхдээ аврагч, гал сөнөөгчдийг идэвх санаачлага, тэсвэр хатуужилтай, өгөгдсөн үүрэг, тушаалыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийн зэрэгцээ хэсгийн бүрэлдэхүүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах.

91. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аврах болон гал түймэр унтраах ажиллагааг явуулах үед энэ дүрмийг хатуу баримтлан үүрэг гүйцэтгэх.

92. Өөрийн хариуцсан хэсгийн гүйцэтгэх үүргийг сайтар мэдэж, түүнийг биелүүлэх арга зүйг боловсруулж, амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хэсгийн ажиллах хугацаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар бүрэлдэхүүнд тайлбарлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

93. Гал түймэр унтраах, аврах ажиллагааны үед аврагч, гал сөнөөгчдийн объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хувийн зэвсэглэмж, хэсгийн албан хаагчдын багаж хэрэгслийн иж бүрдлийг шалгах.

94. Хэсгийн бүрэлдэхүүнд шалган зааварлах хэсэг, аюулгүй байдлыг хангах хэсгийн байрлалыг зааж өгөх.

95. Хорт хий, утаа ялгарсан болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд орохын өмнө албан хаагч нэг бүрийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн бортого дахь агаарын даралтыг шалгаж, ажиллах нийт хугацаа, голомтод ажиллах, буцах хугацааг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомт хүртэл явсан хэсгийн бүрэлдэхүүний хамгийн их агаар зарцуулалтаар тогтооно.

96. Аюулгүй байдлыг хангах хэсэгтэй байнга холбоо барьж түүгээр дамжуулан аврах ажиллагааны болон гал түймрийн нөхцөл байдал, хэсгийн үйл ажиллагааны талаар эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч, шалган зааварлах хэсгийн даргад илтгэх.

97. Барилгын нурсан хийц бүтээц, утаа ихтэй, үзэгдэх орчин хязгаарлагдмал объектод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэж байгаа хэсгийн ахлагч буюу чиглүүлэгч урдах замаа задаргаа хийх гар багажаар тогших, буцах замаа судлах, шалгаж явах үүрэгтэй.

98. Хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгчдийн биеийн эрүүл мэндийн байдал, багаж хэрэгслийн ашиглалт, агаарын зарцуулалтад хяналт тавьж, голомтоос гарах тогтоосон хугацаа болмогц хэсгийн бүрэлдэхүүнийг цэвэр агаарт гаргах.

99. Хэсгийн бүрэлдэхүүнийг нүдэнд үзэгдэхүйц газарт буюу дуут дохио сонсогдох, хөдөлгөөн буюу байрлал тогтоогчид мэдэгдэхүйц, гэрэл, холбоо ашиглаж дохио өгч болох зайнд ажиллуулах.

100. Хэсгийн бүрэлдэхүүний хэн нэг нь үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон буюу аль нэг амьсгалын бие даасан төхөөрөмжинд алдаа заасан, бүрдэл хэсэг ажиллагаагүй болбол бүрэлдэхүүнээрээ гадагш цэвэр агаарт гарч энэ тухай эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчид нэн даруй илтгэх.

101. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж буй хэсгийн бүрэлдэхүүнийг цэвэр агаарт гаргаж амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүр хамгаалах багийг тайлах, бортогоны хаалтыг хаах тушаал өгөх.

Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгчийн үүрэг

102. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгч хэсгийн гүйцэтгэх үүрэг, төхөөрөмжтэй ажиллах хугацааг сайн мэдэж бүрэн биелүүлэх.

103. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж байх үедээ хамт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч болон өөртөө анхаарал тавьж байнгын холбоотой ажиллаж, буцах замаа сайн тогтоож авах.

104. Хамт үүрэг гүйцэтгэж байгаа нөхөртөө тусламж үзүүлэхэд хэзээд бэлэн байж, ямар ч нөхцөлд хэсгийн ахлагчийн шийдвэргүй байрлалаа орхихгүй байх.

105. Цагийн байдлын талаарх өөрчлөлтийн тухай мэдээллийг авралтын ажиллагааны дарга, гал түймэр унтраах удирдагч, өөрийн ажиллаж буй хэсгийн ахлагч нарт цаг алдалгүй тухай бүр нь илтгэж байх.

106. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг бортого дахь агаарын зарцуулалтын тооцоог хийж чаддаг байхын зэрэгцээ даралт хэмжигчийн заалтаар даралтыг хянаж, шаардлагагүй үед ослын товчлуурыг хэрэглэхгүй байх.

107. Аюулгүй байдлыг хангах хэсэг, шалган зааварлах хэсгийн байрлалыг сайн мэддэг байх.

108. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүр хамгаалах багийг тайлах, өмсөх үйлдлийг хэсгийн ахлагчийн шийдвэрээр ёсчлон дагаж биелүүлэх.

109. "Нүүр хамгаалах баг өмс" гэсэн тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүр хамгаалах багийг өмсөнө. Энэ тушаалаар аврагч, гал сөнөөгч бүр дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

109.1. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмссөн амьсгалын бие даасан төхөөрөмжийг мөрлөсөн алба хаагч гар хамгаалах хэрэгсэл (Бээлий)-ийг тайлж баруун, зүүн өвдөгний харалдаа тавьж, хоёр өвдөгөөр өвдөглөн сууна,

109.2. Дуулгай малгайг тайлж хоёр хөлийн завсар тавьна, дуулганы дотор малгай (подкас)-г хүзүүнд угласан байна.

109.3. Нүүр хамгаалах багийг өмсөж чангалуур бүчийг доороос нь дээш чиглэлд хоёр хоёроор нь биеийг дагуулан жигд татаж чангална. Хэт сул болон хэт чанга татахыг хориглоно. Нүүр хамгаалах багийг өмсөх үед нүүр болон баг хоёрын завсар үс болон ямар нэгэн зүйл хавчуулагдаагүй бүрэн суурилж байх ёстой. Нүүр хамгаалах багийг өмсөх үед агаараар хангах хавхлагыг нүүр хамгаалах багнаас салгасан байх ба гадна агаарын хавхлагатай төрлийн төхөөрөмжид агаараар хангах хавхлагийг салгахгүйгээр гадна агаарыг нээсэн байж болно.

109.4. Нүүр хамгаалах багийг нүүрэндээ суурьлуулан чангалсны дараа дуулганы дотуур малгайг нүүр хамгаалах багны ирмэгийг даруулан, харах цонхонд саад болохгүй байхаар өмсөж, дуулга малгайг өмсөн сагалдаргыг чангална.

109.5. Нүүр хамгаалах багийг бүрэн өмссөний дараа амьсгалын бие даасан төхөөрөмжийн бортогыг бүрэн нээж хагас тойрог буцааж эргүүлнэ. Үүний дараа агаараар хангах хавхлагийг нүүр хамгаалах багад холбож гүнзгий амьсгаа авч (гадна агаарын хавхалгатай төрлийн төхөөрөмжийн гадна агаарыг хаасан байна) амьсгалын бие даасан төхөөрөмжийн агаараар хангах системд бүрэн холбогдож,

бээлийг өмссөнөөр амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллахад бэлэн болно. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед арьсны ил харагдах өнгөн хэсгүүд бүрэн далдлагдсан байх ёстой.

110. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэхдээ гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод аль болох ойролцоох цэвэр агаартай газар өмсөнө, тайлна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах нийтлэг зарчим

111. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн нүүр хамгаалах багийг өмсөөд гүн, жигд амьсгалах хэрэгтэй. Хэрэв хүнд хүчир ажил хийж байхад амьсгал давхцах, жигд бус амьсгалах, толгой эргэх, дотор муухайрах зэрэг өөрчлөлт орвол уг ажлыг түр зогсоож, хэд хэдэн удаа гүнзгий амьсгалж, амьсгалаа хэвийн байдалд оруулах ба хэсгийн ахлагчид заавал мэдэгдэнэ.

112. Утаатай орчноос цэвэр агаарт гарах хүртэл нүүр хамгаалах багийг тайлах, багийг авч харах цонхыг арчих, цэвэрлэх зэргийг хатуу хориглоно.

113. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг зааврын дагуу зөв өмсөж хэрэглэнэ. Хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд нэн даруй хэсгийн ахлагчид мэдэгдэж, хэсэг цэвэр агаарт гарах хүртэл төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авна.

114. Амьсгал давчдах, биеийн ерөнхий байдал сулрах, толгой эргэх, дотор муухайрах, шанааны судас хүчтэй цохилж, толгой өвдөх, агаар дутагдах зэрэг шинж тэмдэг илэрсэн үед ослын товчлуурыг дарж агаараар хангана.

115. Амьсгал авахад хүндрэлтэй байвал энэ нь агаараар хангах хавхлаганы ажиллагаа хэвийн биш байна гэж үзэн ослын товчлуурыг үе үе дарах хэрэгтэй.

116. Хэсгийн ахлагчаас “Нүүр хамгаалах баг тайл” гэсэн тушаал өгөхөд хэсгийн бүрэлдэхүүн дуулга малгайг тайлж, хүзүүвч бүхий дотор малгайг авч нүүр хамгаалах багны чангалуурыг доороос нь эхлэн суллан тайлж, бортогоны хаалтыг хаана.

117. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод хайгуулын болон аврах ажиллагааг явуулах амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь хоолойн шугам дэлгэж хушуугаар ус өгөхөд бэлэн орж ажиллах.

118. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь дараах дэг журмыг хатуу сахих хэрэгтэй. Үүнд:

118.1. Чиглүүлэгчээр амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн ахлагч, цоожлогчоор хэсгийн туршлагатай албан хаагч явна. Ямар ч тохиолдолд цувж явах шаардлагатай. Цоожлогч хэсгийн хөдөлгөөний дэг журам болон бүрэлдэхүүний биеийн байдал, буцах замд хяналт тавьж байх үүрэгтэй. Буцах замд цоожлогч чиглүүлж харин хэсгийн ахлагч цоожлогчоор явна.

118.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хугацаанд голомтод ажиллаж байгаа хэсгийн дарга нар хэсгийн бусад алба хаагчийн даралт хэмжигчийн заалтад хяналт тавьж байх үүрэгтэй.

118.3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод амьсгалын бие даасан төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэх үеийн нийт ажиллах хугацааг урьдчилан тооцоолж, хэсгийн албан хаагч нэг бүр голомтод ажиллах, буцах хугацааг мэдэж байх бөгөөд даралт хэмжигчийн заалтанд хяналт тавин ажиллах.

119. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь цэвэр агаартай орчинд ээлж солилцоно. Гэхдээ эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажиллаж байгаа байранд солилцож болно. Амарч буй хэсэг нь нөөц хүч болж дараагийн ажилд бэлтгэнэ.

120. Эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч хорт хий, утаатай нөхцөлд ажиллах эхний үеэс нөөц хүчийг томилох буюу дуудах шийдвэрийг гаргана.

121. Олон хүний амь бие, эрүүл мэндэд аюул учирсан, аврах ажиллагааг яаралтай зохион байгуулах, бага хэмжээний объектод ажиллах шаардлага гарвал аврах зам гарц нь ойрхон тохиолдолд утаатай орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй бие бүрэлдэхүүнийг олон хэсэгт зохион байгуулан ажиллуулж болно.

122. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн нэмэгдэл хүч, шалган зааварлах болон аюулгүй байдлыг хангах хэсэгт үлдсэн албан хаагчид ямар ч үед утаатай орчинд ажиллаж байгаа албан хаагчдад тусламж үзүүлэхэд бэлэн байх ёстой.

123. Хорт хий, утаатай болон хүчилтөрөгчийн дутагдалтай орчинд ажиллаж байгаа хэсгийн бүрэлдэхүүн хүнд байдалд орсон буюу холбоо тасарсан тохиолдолд эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагч нар нөөц хэсгийг нэн даруй явуулж тусламж үзүүлнэ.

124. Хэсгийн ажиллах болон амрах хугацааг эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч, гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр тогтооно.

125. Тэсрэх аюул бүхий хий, ууршилттай байранд аврах болон гал түймэр унтраах, хайгуулын ажлыг хийхдээ амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь резинэн гутал өмсөж, ямар нэгэн оч гарах багаж хэрэгслийг (цахилгаан эрэлтүүлэг) хэрэглэхээс зайлсхийж, өндөр сонор сэрэмж, анхааралтай ажиллана. Хүйтний улиралд амьсгалын бие даасан төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах:

126. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг зөөвөрлөхдөө тусгай зориулалтын дулаалгатай хайрцганд буюу аврах ажиллагааны болон гал түймэр унтраах автомашины аврагч, гал сөнөөгчдийн бүхээгт авч явах ба нүүр хамгаалах багны харах цонхонд үл цантуулагч заавал хэрэглэнэ.

127. Агаарын температур -25°C буюу амьсгалахад хүндрэлтэй орчинд амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүр хамгаалах багийг өмсөх, тайлах хүйтэн агаар гэнэт амьсгалах, хүйтэн шингэн зүйл уух зэргийг хатуу хориглоно.

128. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсэг нүүр хамгаалах багийг зайлшгүй тайлах, өмсөх шаардлага гарвал хэсгийн ахлагчийн шийдвэрээр зөвхөн дулаан, хорт хий, утаагүй орчин, байранд гүйцэтгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний бүрдэл хэсгүүд болон сэлбэг, хэрэгслийг хадгалах, засварлах, бортого цэнэглэх

129. Амьсгалын бие даасан төхөөрөмж түүний сэлбэгийг үйлдвэрийн аюулгүй байдлын зааврын шаардлагын дагуу зөв хадгалах, хэрэглэсний дараа цэвэрлэгээ, ариутгал, үйлчилгээг тогтмол хийж байх нь албан хаагчдын аюулгүй байдал, төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангана. Хадгалахдаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн өөрийнх нь нумарсан хэлбэрт барьж хадгалах ба бортогыг гадны үйлчлэлээс хамгаалсан, дулааны үйлчлэлд тэсвэртэй материалаар уут хийж дээр нь гэрэл ойлгогч байрлуулж, гал түймэр унтраах, аврах ангийн дугаарыг тэмдэглэнэ.

130. Томилгоот ээлжийн хуваарьт байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийг гал унтраах автомашин дотор зөөлөн материалаар доторлосон тусгай хайрцганд бэхэлгээтэйгээр байрлуулж хадгалах ба автомашинд авч явна.

131. Нүүр хамгаалах багны нөөц холболттой амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэсгийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах болон авралтын ажиллагааны үед нэрвэгдэгсдэд хэрэглүүлэх.

132. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн тусгай зориулалтын автомашингүй нэгж, агаар хадгалах нөөц сав, сэлбэг хэрэгслийг бэхэлгээтэй зөөлөвч бүхий тусгайлан бэлдсэн хайрцганд хийж гал түймэр унтраах автомашинд хадгалж, тээвэрлэнэ.

133. Бортогыг хадгалах, тээвэрлэхдээ хаалтыг бүрэн хаасан байх ба гал түймэр унтраах автомашинд бэхэлгээгүй тээвэрлэх, бортогыг хурц үзүүртэй зүйлээр цохих, хатуу гадаргуутай газар унагах, дүүрэн цэнэгтэй үед хэт халаах зэргийг хориглоно.

134. Томилгоот ээлжнээс буусан албан хаагч өөрийн амьсгалын бие даасан төхөөрөмжийн дугаартай тусгай шүүгээнд хадгална. Бортогыг цэнэгтэй, цэнэггүй, засварт гэсэн тэмдэглэл бүхий тусгай тавиур дээр хадгалах ба халаалт, дулааны системээс 1м-ээс доошгүй зайтай $+3^{\circ}\text{C}$ - $+25^{\circ}\text{C}$ -ийн дулаантай, стандартын шаардлага хангасан өрөөнд хадгална.

135. Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан албан хаагч томилгоот ээлжинд гарах, буух, хэрэглэсний дараа дүрмэнд заагдсаны дагуу төхөөрөмж хэвийн ажиллагаатай эсэхийг шалгаж, цэвэрлэгээ, техникийн үйлчилгээг салааны захирагчийн удирдлагын дор хийнэ. Шаардлагатай үед засварчныг дуудаж үйлчилгээг хийхэд туслуулж болно.

136. Албан хаагч өөрөө амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг задалж засахыг хориглоно. Амьсгалын бие даасан төхөөрөмж, түүний бүрдэл хэсэгт гарсан гэмтлийг засварлах, шинээр эд ангийг солих ажлыг засвар үйлчилгээний төв, засварын хэсэг дээр ахлах болон засварчин хийнэ. Засвар үйлчилгээ хийлгэхээр өгөх, авах ажиллагааг төхөөрөмж эзэмшигч өөрөө буюу салааны захирагч хариуцан гүйцэтгэнэ.

137. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг угааж, цэвэрлэсний дараа хатааж угсран хоёрдугаар шалгалтыг хийнэ.

138. Засвар үйлчилгээний төв, засварын хэсэг нь хуваарьт байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжийн 30 хувьтай тэнцэх тооны бортогоны нөөцтэй байх бөгөөд дөрөвний гурав нь бүрэн цэнэгтэй байна. Бортогыг аль болох бүрэн цэнэглэж, хэрэглэх үедээ 90 хувиас багагүй цэнэгтэй байлгана.

139. Бортогыг дараах байдлаар цэнэглэнэ:

139.1. Бортогыг цэнэглэх шахуургыг ажиллуулах сургалтад хамрагдсан амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин ажиллуулна.

139.2. 380 вольтын хүчдэлээр тэжээгдэх агаараар цэнэглэх шахуургыг суурилуулахдаа нийлүүлэгч байгууллага эсвэл мэргэжлийн цахилгаанчнаар цахилгааны холболт угсралтыг хийж гүйцэтгүүлнэ.

139.3. Агаараар цэнэглэх шахуургыг цэвэр, хуурай, нарны гэрэл шууд тусдаггүй хэт халалт болохоос сэргийлж агаарын солилцоо сайтай газар сонгон байрлуулж ажиллуулна.

139.4. Агаараар цэнэглэх шахуургыг ажиллуулахын өмнө өрөө тасалгааг сайтар цэвэрлэж, агааржуулалтын системийг ажиллуулсан байна.

139.5. Бортого цэнэглэх өрөөнд агаарын чанар шалгагч багаж байрлуулах ба цэнэглэхийн өмнө амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин агаарын чанарыг шалгасан байна. Хорт хий, утаа ялгарсан тоос шороо ихтэй газар ажиллуулахыг хориглоно.

139.6. Бортого дахь агаар нь MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага стандарт, олон улсын Grade D/EN 12021 стандартын шаардлагыг хангах, цэвэр аюулгүй байна.

139.7. Бортого цэнэглэх хайрцагт бортогыг босоо хэлбэрт байрлуулна. Бортого цэнэглэх хайрцаг нь хана эсвэл шаланд бэхлэгдсэн, тэсрэлийн аюулаас хамгаалагдсан түгжээтэй, металл материалаар хийгдсэн хайрцаг байна.

139.8. Бортогыг хайрцагт байрлуулсны дараа агаар оруулах холбоосуудыг сайтар холбон чангалж, түгжинэ.

139.9. Төхөөрөмжийг ажиллуулагч гарч болзошгүй аюулаас сэргийлж унтраалгад аль болох ойрхон байж ажиллуулахаас гадна багаж, хэрэгслээр цохих, дээр нь суухыг хориглоно.

139.10. Бортогыг цэнэглэхдээ тухайн савны даралтын стандарт хэмжээнд тохируулж агаар дүүргэх ба бүрэн цэнэглэсний дараа агаараар цэнэглэх шахуургын доторх агаарыг бүрэн гаргасны дараа бортогыг салгана.

139.11. Шахаж буй агаарын чийгшил их байвал бортогонд орох агаарын урсгалд саад болж агаар шахах шахуургын хүчин чадлыг бууруулдаг тул усны цоргыг нээж агаараас шүүгдсэн ус, чийгийг гадагшлуулах арга хэмжээг авна.

139.12. Агаараар цэнэглэх шахуургын агаар орох хоолой руу ус орохоос хамгаалах шаардлагатай.

139.13. Агаараар цэнэглэх шахуургын техник үйлчилгээг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтсон хугацаанд хийх ба тухайн төхөөрөмжийн зориулалтын тос болон агаар шүүгчээр ашиглана

140. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг агаараар цэнэглэх шахуургыг авто тавиулан болон, автомашины угаарын хий, тоос, шороо шууд нэвтрэх өрөө тасалгаанд байруулахыг хориглоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Шахсан агаарын амьсгалын бие даасан төхөөрөмжинд хийх шалгалт

141. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, ажиллагааны үеийн эрсдэлийг бууруулах, найдвартай ажиллагаатай эсэхийг тодорхойлохын тулд тухайн төхөөрөмжийг үйлдвэрлэсэн үйлдвэрийн техникийн засвар үйлчилгээ, ашиглалтын зааврын дагуу дор дурдсан шалгалтуудыг хийнэ.

- 141.1. Нэгдүгээр шалгалт
- 141.2. Хоёрдугаар шалгалт
- 141.3. Гуравдугаар шалгалт
- 141.4. Хэрэглэхийн өмнөх шалгалт

Нэгдүгээр шалгалт

142. Нэгдүгээр шалгалтыг томилгоот ээлжинд гарахын өмнө аврагч, гал сөнөөгч өөрийн биеэр салааны захирагчийн удирдлаган дор хийж гүйцэтгэнэ. Нэгдүгээр шалгалтаар илэрсэн гэмтлийг засварлах боломжгүй бол хоёрдугаар шалгалт хийх хуваарьт шилжүүлэх ба бэлтгэл, бэлэн байдлыг хангасан амьсгалын бие даасан төхөөрөмжөөс нөхөн хангалт хийнэ. Нэгдүгээр шалгалтын дараа төхөөрөмж эзэмшигч бүр салааны захирагчид шалгалтын дүнг илтгэж нэгдүгээр шалгалт хийсэн тухай бүртгэлд бичилт хийж баталгаажуулна. Мөн бэлэн байдлын хуваарьт тавигдаагүй нөөцөд хадгалагдаж байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжид сард 1 удаа нэгдүгээр шалгалтыг амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин хийж гүйцэтгэнэ.

143. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн нэгдүгээр шалгалтаар дараах зүйлсийг шалгана. Үүнд:

143.1. Төхөөрөмжийн гадаад үзлэг хийж нүүр хамгаалах багны харах цонхны шил харагсан, цуурсан, битүүмжлэл алдагдсан эсэх, бэхэлгээний бүч тасарсан, сэмэрсэн эсэх, нүүр хамгаалах багны хавхлагын хайрцаг хэсгийн бүрэн бүтэн байдал, үүргэвчний оосор, түгжээ, бортогоны бүрэн бүтэн байдал, хавхалагын хаалтуудын хэвийн ажиллагааг шалгана;

143.2. Төхөөрөмжийн бортогон дахь даралтыг шалгах ба агаараар хангах хавхлагын хаалт, илүүдэл агаарын хавхлагын хаалтуудыг хааж, бортогоны хаалтыг бүрэн нээснээр манометрын заалтыг харна. 250 баг-аас багагүй даралттай төхөөрөмжийг бэлэн байдлын хуваарьт тавьж ашиглана.

143.3. Агаараар хангах хавхлагын хэвийн үйл ажиллагааг шалгах ба нүүр хамгаалах багийг өмсөж, бортогыг бүрэн нээж, агаараар хангах хавхлагийг нүүр хамгаалах баганд холбож 10 секундээс багагүй хугацаанд жигд амьсгалах ба энэ үед агаараар хангах хавхлага нь ямар нэгэн агаарын алдагдалгүйгээр, хэрэглэгчийн хэрэгцээгээр агаарыг өгч байвал хэвийн гэж үзнэ.

143.4. Нэмэлт агаарын товчлуурын хэвийн ажиллагааг шалгах ба нүүр хамгаалах багыг өмсөж, бортогыг бүрэн нээж, нэмэлт агаарын товчлуурыг дарах ба агаарын урсгал болон, урсгалын дуу чимээг нэмэгдэж байвал хэвийн ажиллагаатай гэж үзнэ.

143.5. Төхөөрөмжийн даралт хэмжигч (Манометр)-ийг шалгах ба бортогыг бүрэн нээж секундомерыг дарснаар 1 минутын хугацаанд төхөөрөмжийн даралтын уналт нь 2 баг-аас хэтрэхгүй бол хэвийн гэж үзнэ.

143.6. Дуут дохиог шалгах ба агаараар хангах хавхлагыг хаах товчлуурыг дарж агаарын урсгалыг хаана, агаараар хангах хавхлагыг нүүр хамгаалах багнаас салгаж, бортогны хаалтыг бүрэн хаана, агаараар хангах хавхлагын агаарын урсгал дамжуулах хэсгийг гарын алгаараа таглаж, хавхлагын хаалтыг нээж, нам даралтын хоолойд дүүрсэн илүүдэл агаарын даралтыг хавхлагаар багаар гаргах бөгөөд манометрын заалт 50-60 bar хүртэл унах үед дуут дохио ажиллаж эхэлвэл хэвийн гэж үзнэ.

143.7. Ухаалаг ажиллагаатай амьсгалын бие даасан төхөөрөмжийн цэнэг хураагуур болон, бусад цахилгаан хүчдэлээр тэжээгдэх тоноглолын хэвийн ажиллагааг шалгана. Цэнэг хураагуурын дүүргэлт 70-аас багагүй хувьтай төхөөрөмжийг бэлэн байдлын хуваарьт тавьж ашиглана.

Хоёрдугаар шалгалт

144. Хоёрдугаар шалгалтыг сард 1 удаа эсвэл их цэвэрлэгээ, ариутгал, үйлчилгээ, засвар хийсэн, 1 дүгээр шалгалтаар гэмтэл илэрсэн болон гуравдугаар шалгалтын дараа тус тус хийнэ. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймэр унтраах ажиллагаа буюу дадлага, сургуулийн явцад амьсгалын бие даасан төхөөрөмжийг шалгах, бортогыг цэнэглэх шаардлага гарвал төхөөрөмж эзэмшигчид шалган зааварлах хэсэг дээр очиж засварчин буюу хэсгийн даргын удирдлага дор хийж гүйцэтгэнэ.

145. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хоёрдугаар шалгалтаар дараах зүйлсийг шалгана. Үүнд:

145.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин нэгдүгээр шалгалтын дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүний дараа амьсгалын бие даасан төхөөрөмжийн туршин шалгах төхөөрөмж (нүүр хамгаалах баг, агаараар хангах хавхалга, нам даралтын хоолой, өндөр даралтын хоолой, даралт бууруулагч, дуут дохиог шалгах төхөөрөмж)-ийг ашиглан туршин шалгана.

145.2. Бортогонд гэмтэл үүссэн байж болзошгүй тохиолдолд бортогоны битүүмжлэл шалгах өндөр даралтын туршин шалгах төхөөрөмжид оруулж туршин шалгана. Бортогоны битүүмжлэлийг шалгахдаа туршин шалгах төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтад хамрагдсан засварчин амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан мэргэжилтний хяналтын дор хийж гүйцэтгэнэ.

145.3. Илэрсэн гэмтлийг засварлах боломжгүй бол гуравдугаар шалгалт хийх хуваарьт оруулна.

Гуравдугаар шалгалт

146. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх, аврагч, гал сөнөөгчдийн хэрэглэж байгаа амьсгалын бие даасан төхөөрөмжинд жилд нэгээс доошгүй удаа 3 дугаар шалгалт хийнэ.

147. Шинээр хүлээн авсан төхөөрөмжид ямар нэгэн гэмтэл гараагүй бол үйлдвэрийн баталгаат хугацаа дууссаны дараа хийнэ

148. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн 3 дугаар шалгалтыг ашиглалт, засвар үйлчилгээний сургалт, дадлагад хамрагдсан амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин нар чиглэл хариуцсан мэргэжилтний хяналтын дор хамтран хийнэ.

149. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангиудад шаардлагатай халдваргүйтэл, цэвэрлэгээ, үйлчилгээг хийх ба амьсгалын бие даасан төхөөрөмж нэг бүрийн бүрдэл хэсгийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу задална.

150. Задлах бүрдэл хэсгийг тусгайлан бэлдсэн гэрэлтүүлэг бүхий зөөлөн гадаргуутай ширээ болон тавцан дээр нүүр хамгаалах баг, агаараар хангах хавхлаг, даралт тохируулагч, нам даралтын болон өндөр даралтын хоолой, даралт хэмжигч, дуут дохио, бортого, бортогыг бэхлэх үүргэвч гэсэн дараалалтай задаргааг хийвэл зохино.

151. Задалсан бүрдэл хэсгийн эд ангийг нарийн шалгаж, цэвэрлэж, ариутгах бөгөөд гэмтэл илэрсэн эд ангийг шинээр солих буюу засварлаж тавина.

152. Буцааж угсрахдаа задаргаа хийсний дагуу хамгийн сүүлд авч тавьсан эд анги, боолт, гайкаас эхлэн угсарч дуусаад 2 дугаар шалгалтыг хийнэ.

153. Гуравдугаар шалгалтаар илэрсэн гэмтлийг засварлах боломжгүй эсвэл бэлэн байдлын хуваарьт 10-аас дээш жил ашиглагдсан амьсгалын бие даасан төхөөрөмжийг актлах хуваарьт оруулна.

154. Гуравдугаар шалгалтыг график, төлөвлөгөөний дагуу цаг тухайд нь хийж байхын тулд шалгалтанд оруулах амьсгалын бие даасан төхөөрөмжийн хуваарийг чиглэл хариуцсан мэргэжилтэн, ахлах засварчин нар бэлтгэл, бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр хийж урьдчилан танилцуулсан байна. Шалгалт хийсэн тухай амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин 3 дугаар шалгалт хийсэн тухай бүртгэлд тэмдэглэл хийж баталгаажуулна.

Хэрэглэхийн өмнөх шалгалт

155. Хэрэглэхийн өмнөх шалгалтыг гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэхийн өмнө амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг нь "Баг шалга" гэсэн хэсгийн ахлагчийн тушаалаар гүйцэтгэнэ. Энэ тушаалаар амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчид төхөөрөмжийг нуруундаа мөрлөсөн байх ба үүрэг гүйцэтгэх ажиллагааны үед хөдөлгөөнд саад болохооргүй өөртөө тохируулсан байна.

156. Шалгалтыг дэс дарааллын дагуу нэг минутаас илүүгүй хугацаанд хийж гүйцэтгэх ба дараах зүйлсийг шалгана. Үүнд:

156.1. Нүүр хамгаалах багны гадна үзлэг хийж харах цонхны шил хагарсан, цуурсан, битүүмжлэл алдагдсан эсэх, бэхэлгээний бүч тасарсан, сэмэрсэн эсэх, нүүр хамгаалах багны хавхлагын хайрцаг хэсгийн бүрэн бүтэн байдлыг нүдээр харж шалгана. Үүний дараа Нүүр хамгаалах баганд агаараар хангах хавхлагийг холбож, (гадна агаарын хавхлагатай төхөөрөмжийн гадна агаарыг хаасан байна), бортогыг нээхгүйгээр нүүр хамгаалах багийг нүүрэндээ тулган барьж амьсгална. Энэ үед амьсгалах боломжгүй байх буюу нүүр хамгаалах баганд ямар нэгэн агаар орж ирэхгүй байвал битүүмжлэл хэвийн гэж үзнэ.

156.2. Бортогыг нээж даралт хэмжигчийн заалтыг харсны дараа амьсгалын бие даасан төхөөрөмж гэмтэлгүй бүрэн ажиллагаатай хэрэглэхэд бэлэн болсон тухайгаа "ахлагч Бат төхөөрөмжтэй ажиллахад бэлэн, даралт 250 bar" гэж хэсгийн ахлагчид илтгэнэ.

156.3. Хэсгийн ахлагч даралт хэмжигчийн заалтыг биечлэн шалгаж, бортого дахь хамгийн бага агаарын даралтыг тогтооно. Шалгалтаар гэмтэл илэрсэн буюу шалгалт хийгээгүй амьсгалын бие даасан төхөөрөмжийг хэрэглэхийг хориглоно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

Амьсгалын бие даасан төхөөрөмжийг цэвэрлэх, ариутгах

157. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг дараах нөхцөлд цэвэрлэж, халдваргүйтгэнэ. Үүнд:

157.1. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажилласны дараа (гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод болон дадлага, сургалт)

157.2. Шинээр хүлээж авсан төхөөрөмж.

157.3. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч арьс, амьсгалын замаар халдварлах халдварт өвчнөөр өвчлөх.

157.4. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн гуравдугаар шалгалт хийх.

158. Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг амьсгалын бие даасан төхөөрөмжийн ахлах засварчин болон засварчин биечлэн хийж гүйцэтгэнэ.

159. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн дотор эд ангийг зориулалтын уусмалд норгосон зөөлөн алчуураар арчина. Тэгэхдээ далдлагдсан буюу оёос бүхий хэсгийг сайн цэвэрлэнэ. Бүх хавхлаг, жийргэвч, пүршийг халдваргүйтгэгч уусмалд 2-3 минутын хугацаатайгаар дүрж ариутгана. Халдваргүйтгэсний дараа бүлээн усаар угааж усыг шүүрүүлж хатаана.

160. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн бүрдэл хэсгийн эд ангийг халдваргүйтгэж цэвэрлэх, үйлчилгээ хийхэд дараах олон Улсын стандартад нийцсэн, зориулалтын уусмал, шингэнийг хэрэглэнэ.

160.1. 70-90 хувийн спиртэн суурьтай халдваргүйжүүлэгч;

160.2. Стандартчилсан бактерицид, туберкулицид үйлчилгээтэй QAC (Quaternary Ammonium Compound) суурьтай уусмал;

160.3. Үйлдвэрлэгчээс зөвшөөрөгдсөн ариутгал, цэвэрлэгээний уусмал (Sekumatic, sekusept, incidin, incidur, silicone tube grease)-ыг уусмал, шингэнийг хэрэглэнэ.

161. Хортой болон аюултай бодис, цацраг, биологийн бохирдолтой орчинд ажилласан алба хаагчийн төхөөрөмж, хамгаалах хэрэгслийг тайлахаас өмнө, бохирдлоос салгах (decontamination) бүрэн цэвэрлэж, халдваргүйтгэл, идэвхжилт сулруулалтыг хийсний дараа тайлна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод тусгаарлагч шүүгч, төхөөрөмжтэй ажиллах

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах үеийн зохион байгуулалт

162. Албан хаагчид ослын бүсэд явсан чиглэлээ тухайн уулын малталтын бэхэлгээ, агааржуулалт, агаарын найрлагад хяналт тавьж, өндөр нам олон төрлийн

малталтад ажиллах болон дулааны өөрчлөлтөд үүрэг гүйцэтгэхдээ ажиллах хугацаанд тогтмол хяналт тавина.

163. Ослын бүсэд алба хаагчид хүчилтөрөгчийн зарцуулалтаа нарийн тооцож, буцаж гарахад шаардлагатай хэмжээгээ сайн мэдэж байх шаардлагатай.

164. Хэрэв ослын бүсэд агааргүй орчинд алба хаагчийн биеийн эрүүл мэнд муудах, тусгаарлагч шүүгч төхөөрөмжид гэмтэл гарвал нөөц тусгаарлагч шүүгч төхөөрөмж хэрэглэн, анхны тусламж үзүүлж, тэр газраас агаарын сорьц авч, ослын үеийн удирдагчид мэдэгдэн газрын гүний удирдлагын төв рүү буцах ба цэвэр агаарт шууд гарна.

165. Аврагч бүр бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагчийн үүргийг биелүүлж байнгын холбоотой ажиллана.

166. Бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч болон аврагчид өөрийн бүлгийн үүрэг зорилгыг тодорхой мэдэж, малталтын байдлыг ажиглан анхаарал болгоомжтой явна.

167. Үүрэг гүйцэтгэж буй бүлэг нь ажлын байрны өөрчлөлт болон тухайн үеийн шаардлагатай бүх мэдээллийг бүлгийн даргад мэдэгдэж, бие биедээ туслах зарчмыг баримтална дур мэдэн бүлгийн байрлалыг орхиж явахыг хатуу хориглоно.

168. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжид гэмтэл илрэх, бие эвгүйдэх ямар нэгэн шинж илэрвэл яаралтай бүлгийн даргад мэдэгдэнэ.

169. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн хүчилтөрөгчийн нөөцийг хянаж, шаардлагагүй үед аваарын хавхалга дарахыг хориглоно.

170. Аврах ажиллагааг "Амны зуулт эрүүний хайрцагтай" гүйцэтгэж байх үед ярихыг хориглоно.

171. Аврагчдын тусгаарлагч шүүгч төхөөрөмж өмсөх талбар, бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч тогтоох ба өмсөхийн өмнө түргэн шалгалт хийлгэнэ. Шаардлага хангаагүй тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллахыг хориглоно. Цэвэр агаартай малталтад бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагчийн зөвшөөрлөөр тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг тайлна. Энэ үед тусгаарлагч шүүгч төхөөрөмж эзэмшигчээс нь 10 метрээс илүүгүй зайд байрлуулна.

172. Аврах ажиллагааг шуурхай удирдахын тулд газрын дээрх болон газрын гүний удирдлагын төвийг байгуулна. Газрын гүний удирдлагын төв нь аюул осол болсон газартай аль болох ойролцоо цэвэр агаарын урсгалд байрлаж ажиллагааг шуурхай удирдлагаар хангах ба бэлтгэл бүлэг болон шаардлагатай тоног төхөөрөмжийг байрлуулна.

173. Зөвхөн хүний амь насыг аврах яаралтай ажлын үед бэлтгэл бүлэггүй ажиллаж болно

174. Агааргүй, үзэгдэх орчингүй нөхцөлд аврагчид дараах тусгаарлагч, шүүгч төхөөрөмжийн шүглэн дохиогоор дараах давтамжаар ашиглана. Үүнд:

174.1. Нэг дохио - Зогс (хөдөлгөөн үед эсвэл ажлаа зогсоо)

174.2. Хоёр дохио – Буц

174.3. Гурван дохио- Урагшаа (хөдөлгөөний үед эсвэл ажлаа үргэлжлүүл)

174.4. Дөрвөн дохио- Аюулаас холд

174.5. Таван дохио -Тусламж хүсэж байна

174.6. Олон дараалсан дохио -Бие муу байна тусламж

175. Агааргүй, үзэгдэх орчингүй нөхцөлд аврагчид босоо болон налуу малталтаар механикжсан тээврийн үед дараах дохиог хэрэглэнэ: Үүнд

175.1. Нэг дохио-зогс;

175.2. Хоёр дохио - дээшээ;

175.3. Гурван дохио – доошоо

Агааргүй болон утаатай үзэгдэх орчин хязгаарлагдмал малталтад аврах ажиллагааг зохион байгуулах

176. Үзэгдэх орчин хязгаарлагдмал болон 1 метрээс намхан малталтаар хайгуулын ажиллагаа гүйцэтгэхдээ аврагчид хоорондоо хамгаалах ба чиглүүлэгч олсоор холбогдсон байна. Малталтаар хайгуулын ажиллагаа гүйцэтгэхдээ аврагчид ташуу байрлаж урагшилна. Бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч урд нь малталтын хана, таазыг модоор тогшиж үзэн, бас мухар малталт байгаа эсэхийг шалгана.

177. Бүлэг агааргүй орчинд нэрвэгдэгчийг илрүүлбэл нэн даруй эмнэлгийн анхны тусламж үзүүлэн, хиймэл амьсгалын төхөөрөмж залгаж, цэвэр агаарын урсгалд хүргэх үүрэгтэй мөн ослын газраас агаарын дээж авна.

178. Хэрвээ 2 болон түүнээс дээш нэрвэгдэгчийг зэрэг зөөх боломжгүй тохиолдолд тусламж үзүүлэхээр бэлтгэл бүлгийг дуудах ба эхний ээлжид амьсгалтай нэрвэгдэгчийг зөөвөрлөнө.

179. Бүлэг нэрвэгдэгчийг цэвэр агаарын урсгалд гаргаж эрүүл мэндийн байгууллагын ажилтанд хүлээлгэн өгнө.

180. Хайгуулаар малталтад амьд хүн үлдээгүй нь тодорхой болсон үед нэрвэгдэгчийг гаргах ажиллагааг зөвхөн аюулгүй ажиллагааг бүрэн хангасны дараа гүйцэтгэнэ.

181. Хүчилтөрөгчийн тооцоог доорх аргаар хийнэ. Үүнд :

181.1. Тусгаарлах шүүгч төхөөрөмжийн бортогыг нээхэд 400 литр (200 кгс/см²) байх ба түүнээс хүрэх цэг хүртэл, буцахад зарцуулагдах, үл хөндөх нөөцийг хасаж , тухайн цэгт ажил гүйцэтгэх хугацаанд зарах хүчилтөрөгчийн хэмжээ гарна. Үүнийг томъёолбол

$$181.2. P_{аж} = 400 - (P_{хүр} + P_{буц} + 50_{кгс/см2})$$

181.3. $P_{аж}$ - тухайн цэгт ажил гүйцэтгэхэд зарах хүчилтөрөгчийн хэмжээ

181.4. $P^{*ур}$ -тухайн цэгт хүрэх замд гүйцэтгэхэд зарах хүчилтөрөгчийн

хэмжээ

181.5. $P_{буц}$ - тухайн цэгээс буцахад шаардлагатай хүчилтөрөгчийн

хэмжээ

181.6. Хэрэв шаардлагатай хүрэх газрын маршрут нь тэгш буюу налуу /10° хүртэл/ малталтаар явах , буцахдаа мөн налуу малталтаар буцах бол замд зарцуулах хүчилтөрөгчийн хэмжээг $P_{буц} = P^{хүр} + 50_{кгс/см^2}$ (адил хэмжээтэй)

181.7. Хэрэв буцах зам нь 10° - с илүү бол зарцуулах хүчилтөрөгчийн хэмжээг $P_{буц} = 2P^{хүр} + 50_{кгс/см^2}$ (хоор дахин их байхаар) тус тус тооцдог.

Хүйтний улиралд тусгаарлагч төхөөрөмжтэй ажиллах

182. Тухайн осол гарсан уурхай, уулын үйлдвэрлэлийн аж ахуй нэгж нь тусгаарлах шүүгч төхөөрөмж цэнэглэх, засвар үйлчилгээ хийх болон бүлгийн алба

хаагч амрах дулаан байраар хангана.

183. Хүйтний улиралд тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллахдаа агаар дамжуулах хоолойг сайн хатаасан байх ёстой.

184. Хүйтний улиралд тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн шохойг хамгийн бага чийглэгтэй байхад цэнэглэнэ.

185. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн бортогыг хуурайшуулсан эмнэлгийн зориулалттай хүчилтөрөгчөөр цэнэглэнэ.

186. Газрын гүний удирдлагын төвийг дулаан малталтад байрлуулна.

187. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг дулаан орчинд өмсөх ба мөн 0 градусаас доош температуртай орчинд түр амрахдаа тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг салгаж болохгүй.

188. Хэрэв тусгаарлагч шүүгч төхөөрөмжөө зайлшгүй хүйтний улиралд өмсөх тохиолдолд 10 минутаас доошгүй хугацаанд амьсгалаар дулаацуулж, жигдрүүлсний дараа үүрэг гүйцэтгэнэ.

189. Дүрэмд заасан ажиллах хугацааг хэтрүүлж болохгүй. 0°C-оос -5°C градуст тайлсан тусгаарлагч шүүгч төхөөрөмж 15 минутаас дээш хугацаанд, -5°C градусаас доош температурт 5 минут болсон тусгаарлагч, шүүгч төхөөрөмжийг тус тус дахин өмсөж ажилд орохыг хориглоно. Энэ тохиолдолд тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг дулаан зориулалтын байранд байлгаж хатаан дахин цэнэглэнэ.

190. Хүйтний улиралд тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах, болон зорчихдоо есдүгээр хавсралтад заасан хугацааг баримтална.

Утаатай орчинд тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах

191. Утаатай орчинд хайгуул хийхдээ цуваанд орж, 1-1,5 м зайтай труба, хоолой, төмөр зам малталтад байрлуулсан тоног төхөөрөмжүүдийг баримжаалан явна. Хайгуулын ажиллагаа гүйцэтгэж буй үед аврах бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч цоожлогч хоёрын хоорондох зай 8 метрээс илүүгүй байна.

192. Бүлгийн алба хаагчид тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн холбогчоор холбогдож, холбооны шугамыг сунгаж холбоо барих нөхцөлийг хангаж ажиллана.

193. Бүлгийн дарга-аврах ажиллагааны зааварлагч нь цоожлогчтой байнга холбоо барьж явна. Цоожлогч нь бүлгийн дарга аврах ажиллагааны зааварлагчийн орлогч буюу 5 дугаар тоот байна.

194. Бүлгийн дарга-аврах ажиллагааны тэмтрэгч ашиглан малталтын байдал, онгорхой босоо амны нурал зэргийг тогтоон илрүүлэх ёстой.

195. Нэрвэгдэгчийг хайх тохиолдолд налуу болон хэвтээ малталтаар бүлэг ташуулдаж урагшилна.

196. Буцаж гарахад өмнө нь сунгасан холбооны шугам явах замын чиг баримжаа болно.

197. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн нүүр хамгаалах багыг хөлрөхөөс хамгаалж тусгай уусмалаар арчсан байх ёстой.

198. Газрын гүний удирдлагын төвд байгаа бэлтгэл бүлэг нь утаатай орчинд ажиллаж буй бүлэг болон удирдлагатай цагийн байдлыг мэдээллэж байнгын холбоотой ажиллана.

Хортой, аюултай хийтэй орчинд аврах ажил явуулах

199. Уурхайд аврах ажил гүйцэтгэх үед агааргүйгээс гадна тэсрэх аюултай

хийнүүдийн ялгарал аюултай хэмжээнд хүрэх тохиолдолд тэсрэлт үүсгэхгүйн тулд доорх заалтыг мөрдөж ажиллана. Үүнд:

199.1. Тухайн далд уурхайд хэмжих, хянах хэрэгслийг ашиглан уурхайн агаарын найрлагыг тогтмол хянаж байх ёстой.

199.2. Тэсрэх аюултай хийн ялгаралтай ажлын байранд оч үүсгэх, гал гаргах явдал хатуу хориотой. (Дуулганы гэрлийг унтрааж, асааж болохгүй) Тэсрэмтгий хийн хэмжээ аюултай хязгаарт хүрч буй малталтад цахилгаан тэрэг явуулахыг хориглоно.

199.3. Ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд оч үүсгэхээс сэргийлсэн хамгаалалттай байх ёстой. (агаар метаны хольцын авалцах нөхцөл бүрдүүлэхгүй байх)

199.4. Нүүрсний тоосны дэгдэлттэй орчинд /дэгдэмхий 15%-с дээш/ тоосыг тэсрэх аюултай хэмжээнд хүрэхээс сэргийлэх арга хэмжээнүүдийг авна. Мөн нүүрсний өөрөө шатахаас сэргийлэх арга хэмжээ авна.

199.5. Тэсрэмтгий хийн ялгаралтай малталтад цахилгаан залгахаар бол зөвхөн ослын үеийн удирдагч, уул уурхайн аврах ангийн удирдагч нарын шийдвэрээр цахилгаан тоног төхөөрөмж, шугамын бүрэн бүтэн байдал, хамгаалалтыг шалгаж. хүмүүсийг аюулгүй гаргасны дараа гүйцэтгэнэ.

199.6. Метан хийтэй малталтад агааржуулах систем маш сайн байж, тогтмол агааржуулах шаардлагатай.

199.7. Метаны тэсрэлтийн хязгаар 4.4%-17% хүртэл болон метан 2% хүрсэн тохиолдолд аврах ажиллагааг зогсоож аврагчид аюулгүй орчинд гарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тусгаарлагч шүүгч төхөөрөмж эзэмшигчийн үүрэг

200. Аюул ослыг арилгах ба аврах ажлууд нь тусгаарлагч шүүгч төхөөрөмж эзэмшигчээс сэтгэл санааны ба ур чадвараа дайчлан ажиллах тэсвэртэй байх.

201. Тусгаарлагч шүүгч төхөөрөмж эзэмшигч нь удирдах дарга нараас өгөгдсөн тушаал даалгаврыг цаг тухайд нь биелүүлж байнгын холбоотой байх.

202. Нэрвэгдэгчид яаралтай тусламж үзүүлэх, уулын аврах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг маш сайн эзэмшиж хурдан шуурхай ажиллуулдаг байх.

203. Өгдөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай, гүйцэтгэх ажиллагааны дарааллыг мэддэг байх.

204. Тогтоосон мэдээлэл холбооны аргыг хэрэглэж, илэрсэн зөрчил болон нөхцөл байдлын тухай бүлгийн дарга аврах ажиллагааны зааварлагчид мэдээлнэ. (дохио, шохойгоор бичих г.м)

205. Үүрэг гүйцэтгэсний дараа өөрийн тусгаарлагч шүүгч төхөөрөмж болон багаж хэрэгслийг цэвэрлэн шалгаж дараагийн ажиллагаанд бэлэн бэлтгэх.

206. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажил үүрэг гүйцэтгэх үед холбогдох дүрэм, журам, аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал биелүүлэх үүрэгтэй.

Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн эвдрэл гэмтэл

207. Сорох хавхалга эвдэрсэн бол амьсгал гаргах бүрд зайлшгүй сорох хоолойг хавчиж өгнө.

208. Амьсгал гаргах хавхалга эвдэрвэл ямар нэгэн үйлдэл хийх хэрэггүй.

209. Хоёр хавхалга хоёулаа эвдэрвэл амьсгаа гаргах бүрд сорох хоолойг хавчиж, хөдөлгөөнөө сааруулж, аль болох гүнзгий амьсгалахаас зайлсхийн бортогоны даралтыг хянана.

210. Амьсгалын хоолойнууд гэмтэхэд яаралтай гэмтсэн газрыг гараараа таглаж, аюулын хавхалгаар хүчилтөрөгч өгч, боломжоороо цоорхойг хаана.

211. Хэрэв даралт хэмжигч буюу хялгасан хоолой эвдэрвэл яаралтай хаалтыг хаана.

212. Дээрх бүх тохиолдолд цэвэр агаарт яаралтай гарах ёстой.

Тусгаарлагч шүүгч төхөөрөмжид үзлэг шалгалт хийх

213. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн битүүмжлэл шалгах төхөөрөмжөөр сард 2-с доошгүй удаа шалгаж, бүлгийн дарга, амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин гарын үсэг зурж баталгаажуулах ба албаны дарга аврах ажиллагааны удирдагч хяналт тавина. /Хавсралт-12/

214. Тусгаарлагч шүүгч төхөөрөмж 4 цаг ажилласны дараа тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн шүүгч шохойг сольж жижиг бортогыг хүчилтөрөгчөөр цэнэглэж тусгаарлагч шүүгч төхөөрөмжөө тус багажаар шалгаж, төхөөрөмжийн бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтөлнө. Шалгасан тухай тусгаарлагч шүүгч төхөөрөмж эзэмшигч гарын үсэг зурж бүлийн дарга хяналт тавьж гарын үсэг зурсан байна. Шалгалт хийгдээгүй бол агааргүй хортой хийтэй орчинд ажиллахыг хориглоно.

215. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжид түргэн шалгалтыг дараах дарааллаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

215.1. Амьсгал гаргах хавхалга шалгах: Амьсгал авах хоолойг хавчиж сорно энэ үед сорогдохгүй байвал амьсгал гаргах хавхалга хэвийн гэдгийг илтгэнэ.

215.2. Амьсгал авах хавхалга шалгах: Амьсгал гаргах хоолойг хавчиж үлээнэ энэ үед урдаас түлхэж байвал амьсгал авах хавхалга хэвийн гэдгийг илтгэнэ.

215.3. Дотроос гадагш гарах битүүмжийг шалгах: Тусгаарлагч шүүгч төхөөрөмжөөс агаарыг сорж нүүр хамгаалах багийн хажуугаар гараа хийж татаж гадагш гаргана.

215.4. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжид автомат өгөлтийг шалгах: Битүү байдалд үлээж хүчилтөрөгчийн бортогыг онгойлгож Тусгаарлагч шүүгч төхөөрөмжөөс агаарыг сорж нүүр хамгаалах багын хажуугаар гараа хийж татаж гадагш гаргана энэ үед автомат өгөлт шуугьсан чимээ гарвал хэвийн гэдгийг илтгэнэ.

215.5. Илүүдлийн хавхалга шалгах: Нүүр хамгаалах багын хажуугаар гараа хийж татаж гаднаас агаар сорж дотогшоо нь үлээнэ. Энэ үед илүүдлийн хавхалга дуугарна.

215.6. Аваарын хавхалга шалгах: Аваарын хавхалгыг 2-3 удаа дарахад шуугих чимээ гарах нь хэвийн илтгэнэ.

216. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин засварын тоног төхөөрөмж болон тусгаарлагч төхөөрөмжийг үзлэг шалгалтад хамруулах жил улирлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ба албаны дарга аврах ажиллагааны удирдагчаар хянуулж захирагчаар батлуулна.

Тусгаарлагч шүүгч төхөөрөмж хадгалах, тээвэрлэх

217. Тусгаарлагч шүүгч төхөөрөмж хадгалах өрөөний дулаан, чийглэг тохирсон байна.

218. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг тээвэрлэхдээ тусгайлан бэлдсэн хайрцаг саванд ус чийг болон цохилт доргилтоос хамгаалан авч явна.

219. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг хадгалахдаа тос, масло, бензин зэрэг түргэн шатамхай зүйлээс тусад нь хадгалах ба галын аюулгүй байдлыг анхаарна.

220. Бүрэн цэнэгтэй тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг хадгалахдаа 10 хоног тутамд заавал нэг удаа шалгаж байх ба бат бөх саванд хийж хадгална. Энэ хугацаанд хэрэв тусгаарлагч шүүгч төхөөрөмж шаардлага хангахгүй болсон бол шалгаж, дахин цэнэглэн ажилд оруулна.

221. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг доргиох, унагаах явдлыг хатуу хориглоно.

222. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг тээвэрлэж ирсний дараа дахин шалгалт хийж, ажилд оруулна.

223. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь хүйтний улиралд дулаан битүүмжлэл сайн байх шаардлагатай.

224. Лабораторийн шинжилгээгээр бүх үзүүлэлтийг нь тодорхойлон шаардлага хангасан шохойг хэрэглэнэ. Үүнд:

224.1. Шохойг шалгасан он, сар, өдөр

224.2. Суманд хийсэн жин

224.3. Шохойны зэрэг, дугаар

224.4. Хийсэн савны дугаар зэргийг тодорхой бичнэ.

225. Шохойны чийглэг нь: 16%-21%, нүүрстөрөгч 4%-с ихгүй байхад хэрэглэж болно. 6%-7% чийглэгтэй шохойг сургуулийн үед хэрэглэнэ. Хэрэв шохойг тусгаарлагч шүүгч төхөөрөмжид хийгээд 3 сараас дээш хугацаа өнгөрсөн бол дахин шинээр цэнэглэх ёстой (Хавсралт-9)

Тусгаарлагч шүүгч төхөөрөмжийн сум, шохойг хадгалах

226. Суманд 2-2,2кг-с доошгүй жинтэй шүүгч шохойг хийж дүүргэсэн байна.

227. Сумны бүрэн бүтэн байдлыг шалгаж, тусгайлан тэмдэглэсэн байна.

228. Таглааг жийрэглэн сайн таглаж, чангалж тавина. Таглаагүй хадгалах хориотой.

229. Сумны таглаа бүрэн бүтэн байдалд хяналт тавих ёстой.

230. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжид тусгай импортын шохойг лабораторийн шинжилгээгээр ажил сургуульд тохирсон гэсэн дүгнэлт гаргасны дараа ашиглана.

231. Лабораторийн шинжилгээгээр ажил сургуульд тохирсон гэдэг дүгнэлт гаргасны дараа шохойг хэрэглэнэ.

232. Химийн шингээгч шохой битүү металл ломботой саванд хадгалагдах ба түүний агуулах нь хуурай, ус чийгээс хамгаалагдсан байх ёстой.

233. Химийн шингээгч шохой хадгалах агуулах нь 5°C-аас 25°C дулаантай байна.

234. Хадгалах баталгаат хугацаа нь нэг жил энэ хугацаанаас хадгалж буй сав бүрээс сорьц авч чийглэг, нүүрсхүчлийн хийг шинжилнэ. Хэрэв үзүүлэлт хэвийн байвал хугацааг нэг жил хүртэл сунгаж болно.

Тусгаарлагч, шүүгч төхөөрөмж хэрэглэн үүрэг гүйцэтгэх үед хүнсээр хангах

235. Хэрэв тусгаарлагч шүүгч төхөөрөмж хэрэглэн 4 цагаас илүү хугацаагаар үүрэг гүйцэтгэсэн бол аврах ажиллагааны удирдагч нь аврагчдыг хоол, хүнсээр хангах хариуцлагатай ажилтан томилно.

236. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах үед биеийн алдагдсан энергийг нөхөх зорилгоор хэрэглэх хоолны илчлэг 3750-4200 ккал байх ёстой. Илчлэгийн дараах байдлаар хуваарилна. Үүнд:

236.1. Уурхайд орохын өмнө 25%-30%

236.2. Ажлын завсарлагаар 20%-25%

236.3. Ээлжийн төгсгөлд 40%-45%

237. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах орчин халуун их байх үед хоолны илчлэгийг уурхайд орохын өмнө 10-15% багасгах шаардлагатай.

238. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах үеийн хоолны дэглэм нь ердийн үеийнхээс ялгаатай байна.

239. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй үүрэг гүйцэтгэхээс өмнө ам цангаах, хүчил ихтэй, гэдэс дүүргэх хоол хүнс даршилсан ногоо, хийжүүлсэн ундаа зэргийг хэрэглэхийг хориглоно.

240. Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн болон хэрэглэсний дараа тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллахыг хатуу хориглоно.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

СУРГАЛТ, ДАДЛАГА, ХӨТЛӨХ БАРИМТ БИЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хийх сургалт, дадлага

241. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч нь төхөөрөмжтэй ажиллах үед агааргүй, үзэгдэх орчин хязгаарлагдмал, өндөр температуртай чийглэг ихтэй орчинд амьсгалаа зөв хуваарилж сурсан байх.

242. Дадлага сургалт нь бодит байдалд ойртсон, хийгдэж болох төрөл бүрийн даалгавар гүйцэтгэхийг шаардсан байна. Дадлага сургалтад амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч бүх алба хаагчдын хамруулна.

243. Дасгалыг ажлын хөнгөнөөс, хүнд рүү шилжих буюу хөнгөн, хүндийг ээлжлэх дарааллаар хийнэ.

244. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй хийх дасгалын үед ажлын хүнд, хөнгөн, хүчилтөрөгчийн хэрэглээгээр тодорхойлно. Дасгалын үед амрах давтамж, үргэлжлэл нь гүйцэтгэх ажлын хөнгөн, хүндийн зэргээс хамаарна.

245. Шахсан агаарын амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дадлага сургалтыг дараах байдлаар хийж гүйцэтгэн: Үүнд:

245.1. Хөнгөн ачаалал: Амьсгалын бие даасан төхөөрөмжийг объектын гал түймрээс хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хамт норматив хугацаанд өмсөх, нүүр хамгаалах багийн харах цонхыг битүүлж, гадна агаар дээр амьсгалж, үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөлд тогтоосон цэгт хүрэх, давчуу орон зайд саадыг туулж, нэрвэгдэгчийг олох, амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хугацааг тооцох зэрэг даалгавар гүйцэтгэнэ.

245.2. Дунд зэргийн ачаалал: Мананцар үүсгэгчээр (Хиймэл утаа) дүүргэсэн, давчуу орон зайд амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллаж саадыг туулах,

нэрвэгдэгчийг олох, зөөвөрлөх, багаж хэрэгслийг зөөвөрлөх, аврах олс, олон ажиллагаатай аврах гогцоог ашиглах зэрэг даалгавар гүйцэтгэнэ.

245.3. Хүнд ачаалал: Бодит утаа, өндөр температур бүхий утаа, дулааны байгууламжид (утааны камер)-т амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах, гал түймэр унтраах тархалтыг гүйцэтгэх, хаалга, цонх онгойлгох болон барилга байгууламжийн хийц бүтээцийг задлах аргаар агаарын солилцоог зөв зохион байгуулах, хайгуулын ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгчийг олох, газар доорх болон өндөр давхраас нэрвэгдэгчийг зөөвөрлөх зэрэг даалгаврыг гүйцэтгэнэ.

246. Тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй ажиллах дадлага сургалтыг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ: Үүнд:

246.1. Хөнгөн ачаалал: даралтат усны цэг хэрэглэх, цахилгаан хөрөөгөөр мод хөрөөдөх, татах төхөөрөмж ажиллуулах, гал унтраагуур ашиглах мөн даралтат данхраад болон бусад аврах ажиллагаанд хэрэглэгддэг багажуудыг ажиллуулна.

246.2. Дунд зэргийн ачаалал: Хэвтээ болон налуу малталт бэхлэх, хэвтээ болон налуу малталтаар явах, мод, даавуу, тоосго, шавраар хаалт хийх, осолдогчийг татах төхөөрөмж, галын цахилгаан шахуурга хэсгийн агааржуулах сэнс ажиллуулах зэрэг даалгавар гүйцэтгэнэ.

246.3. Хүнд ачаалал: Модны тайрдас, блок бетоноор хаалт хийх, нэрвэгдэгчтэй дамнуурга хэвтээ болон налуу малталтаар шатаар зорчих, налуу, хэвтээ малталтаар ачаа зөөх гар хөрөөгөөр мод хөрөөдөх зэрэг даалгавар гүйцэтгэнэ.

246.4. Маш хүнд ачаалал: Давчуу орон зайн малталтаар явахдаа тусгаарлагч шүүгч багаа элгэндээ авч мөлхөж даалгавар гүйцэтгэнэ. Тусгаарлагч шүүгч багтай дасгалын үед дуудлагаар ажиллахад шаардагдах багаж хэрэгсэлтэй гүйцэтгэнэ. Эрэн хайх, аврах салбарын дарга удирдаж хийлгэх ба эмч, сэтгэл зүйч, амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин хамт байна.

247. Дадлага сургалтын явцад гал сөнөөгч, аврагч бүр өөрийн судасны цохилт, биеийн байдалд хяналт тавьж, хэвийн бус бол удирдагчид яаралтай мэдэгдэнэ.

248. Дадлага сургалтын үед шатлал бүрийн төгсгөлд зүрхний зохилт 150 р.минутаас хэтэрч үл болно.

249. 15 минут сууж амарсны дараа цусны даралт 90 мм.муб-с доош буухгүй бол дасгалаас чөлөөлнө.

250. Алба хаагч нь тусгаарлагч шүүгч төхөөрөмжтэй аврах ажиллагаа болон дадлага сургалт хийсэн үед удаа дараа биеийн байдал муудсан бол эмчилгээ хийлгэх шаардлагатай.

Хөтлөх баримт бичиг

251. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигч бүрд нэгдүгээр хавсралтын дагуу бүртгэл хөтөлнө. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн бүртгэлийг засвар үйлчилгээний төв, засварын хэсэг дээр хөтөлж хадгална.

252. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн бүртгэлийг дараах албан тушаалтнууд эрхлэн хөтлөнө. Үүнд:

253. Салааны захирагч, бүлгийн дарга, амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин.

254. Салаа, бүлгийн орон тоонд ороогүй албан хаагчдыг амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан ахлах засварчин болон засварчин.

255. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Үндэсний аврах бригад, Уул уурхайн аврах ангийн амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан албан хаагчид.

256. Амьсгалын бие даасан төхөөрөмж эзэмшигчийн хариуцсан амьсгалын бие даасан төхөөрөмжийн мэдээлэл мөн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал зэргийг хоёрдугаар хавсралтын хүснэгтийн дагуу хөтөлнө.

257. Амьсгалын бие даасан төхөөрөмжид хийгдэх шалгалтууд, бортого цэнэглэлтийн байдал, төхөөрөмжтэй ажилласан хугацааны тэмдэглэл, техникийн үзлэгийн бүртгэлийг гуравдугаар хавсралтын дагуу хөтөлнө.

258. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэйгээр гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн хэсгийн ажиллагааг тооцох хуудсыг дөрөвдүгээр хавсралтын дагуу хөтөлнө.


259. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах хэсгийн албан хаагчийн хөтлөх хүснэгтийг тавдугаар хавсралтын дагуу хөтөлнө.

260. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажилласан бүртгэлийг зургаадугаар хавсралтын дагуу хөтөлнө.

261. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг, төвийн байранд байх багаж, хэрэгслийн жагсаалтыг долоодугаар хавсралтын дагуу бүрдүүлэн байрлуулж бүртгэлийг хөтөлнө.

262. Битүүмжлэл шалгах төхөөрөмжөөр тусгаарлагч шүүгч төхөөрөмжийг шалгасан тухай бүртгэлийн хуудсыг арван хоёрдугаар хавсралтын дагуу тус тус хөтөлнө.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
 А/... дугаар тушаалын 12 дугаар хавсралт
 485



**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖ
 ЭЗЭМШИГЧИЙН БҮРТГЭЛ**

Овог: _____
 Нэр: _____
 Төрсөн огноо: _____
 Албан тушаал: _____
 Цол: _____
 Ажилласан жил: _____
 Харьяалал: _____

Амьсгалын бие даасан төхөөрөмж ашиглах зөвшөөрөл:
 Зөвшөөрөл олгосон огноо: _____
 Хүчинтэй хугацаа: _____
 Онолын мэдлэгийн шалгалтын оноо: _____
 Дадлага ажлын шалгалтын оноо: _____

Эрүүл мэндийн үзлэгийн тэмдэглэл


Эрүүл мэндийн үзлэгт орсон огноо			Эрүүл мэндийн үзлэгт орсон огноо.....		
Асуумж	Тэмдэглэл	Гарын үсэг	Асуумж	Тэмдэглэл	Гарын үсэг
Сүрьеэ- Мэдрэл- Дотор- Мэс засал- Чих хамар хоолой- Нүд- Арьс өнгө-			Сүрьеэ- Мэдрэл- Дотор- Мэс засал- Чих хамар хоолой- Нүд- Арьс өнгө-		
Эрүүл мэндээр төхөөрөмжтэй ажиллаж болно, болохгүй (доогуур нь зур) Болохгүй шалтгааныг тодорхой бичнэ. Эрүүл мэндийн үзлэгийн комиссын дарга			Эрүүл мэндээр төхөөрөмжтэй ажиллаж болно, болохгүй (доогуур нь зур) Болохгүй шалтгааныг тодорхой бичнэ. Эрүүл мэндийн үзлэгийн комиссын дарга		

Хариуцсан төхөөрөмжийн тухай мэдээлэл

Хариуцсан төхөөрөмжийн төрөл	Хариуцсан төхөөрөмжийн төрөл	Хариуцсан төхөөрөмжийн төрөл
.....
Үйлдвэрлэсэн огноо	Үйлдвэрлэсэн огноо	Үйлдвэрлэсэн огноо
.....
Ашиглалтад орсон огноо	Ашиглалтад орсон огноо	Ашиглалтад орсон огноо
.....
Төхөөрөмжийн дугаар	Төхөөрөмжийн дугаар	Төхөөрөмжийн дугаар
.....

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны... дугаар сарын...-ны өдрийн
 ... тушаалын... дугаар хавсралт


485



АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН БҮРТГЭЛ

Ашиглалтад орсон огноо	АБДТ-ний дугаар	АБДТ-ний серийн дугаар	Шалгалт хийсэн огноо	Хэддүгээр шалгалт хийсэн	Хийгдсэн засварын төрөл, сольсон эд ангийн нэр	Төхөөрөмжтэй ажилласан гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймэр сургуулийн лугаар	Төхөөрөмжийн ажилласан хугацаа цаг, минут	Бортого цэнэглэсэн огноо	Бортогоны даралт	Шалгалт, бүртгэл хийсэн албан хаагчийн гарын үсэг	Хянасан албан хаагчийн гарын үсэг

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
 А/... дугаар тушаалын 04 дүгээр хавсралт
 1485



**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ХЭСГИЙН
 АЖИЛЛАГАА ТООЦОХ ХУУДАС**

№	Анги салбарын дугаар	Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсэг						Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах хэсгийн бүрэлдэхүүний нэр	Тайлбар	
		Ажиллаж байгаа			Амарч байгаа		Нөөцөд			
		Төхөөрөмж хэрэглэсэн Хугацаа	Голомтоос гарах хугацаа	Аюулгүй байдлыг хангах хэсэгт ирсэн хугацаа	Эхэлсэн цаг	Дуусах цаг	Эхэлсэн цаг			Дууссан цаг

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
4/... дугаар тушаалын 05 дугаар хавсралт
485



АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ХЭСГИЙН АЛБАН ХААГЧИЙН ХӨТЛӨХ ХҮСНЭГТ

д/д	Анги, салбарын дугаар	АБДТ-тэй ажиллах хэсгийн албан хаагчдын тоо	Голомтод орсон албан хаагчдын тоо	Голомтоос гарсан албан хаагчдын тоо	Хамгийн бага агаарын даралтын заалт	АБДТ-тэй ажиллах хэсгийн голомтод ажиллах хугацаа

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн
А... дугаар тушаалын 06 дугаар хавсралт
АБС




АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖТЭЙ
АЖИЛЛАСАН БҮРТГЭЛ







Төхөөрөмжтэй ажилласан огноо	Ямар төрлийн төхөөрөмж	Төхөөрөмжийн дугаар	Төхөөрөмжтэй ажилласан гал түймэр, аюулт үзэгдэл, осол, гал түймэр сургуулийн дугаар	Төхөөрөмжтэй ажилласан цаг, минут	Тэмдэглэл хөтөлсөн албан хаагчийн гарын үсэг








---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
 А... дугаар тушаалын 12 дугаар хавсралт
 1485







**АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ХЭСЭГ,
 ТӨВИЙН БАЙРАНД БАЙХ БАГАЖ, ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ**








д/д	Багаж хэрэгслийн нэр	Тоо ширхэг	Жишиг фото зураг
1	2	3	4
Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хадгалах, туршин шалгах өрөө			
1	Ширээ (Оффис)	1 ширхэг	
2	Компютер	1 ширхэг	
3	Принтер	1 ширхэг	
4	Бичгийн тавиур	1 ширхэг	
5	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хадгалалт, засвар үйлчилгээний хөтлөгдөх бичгийн хавтас	1 ширхэг	
6	Иж бүрэн амьсгалын бие даасан төхөөрөмж хадгалах шүүгээ, тавиур	1 ширхэг	

7	Нөөц бортого хадгалах шүүгээ, тавиур	1 ширхэг	
8	Засвар үйлчилгээ хийх багажийн багц (жижиг багаж)	1 багц	
9	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн үзлэг шалгалт, засвар үйлчилгээний ширээ	1 ширхэг	
10	Нөөц сэлбэг, багаж хэрэгсэл хадгалах тавиур шүүгээ	1 ширхэг	
11	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн битүүмжлэл туршин шалгах төхөөрөмж (АБДТ-ийн засварын төвд байрлуулна)	1 ширхэг	
12	Бортогоны битүүмжлэл шалгах төхөөрөмж (АБДТ-ийн засварын төвд байрлуулна)	1 ширхэг	
13	Амьсгалын бие даасан төхөөрөмжийн техник үзүүлэлт, задаргааны зарчим, цэвэрлэгээ ариутгал хийх зааварчилгааны зурагт самбар	2 ширхэг	

14	Ариутгал цэвэрлэгээний бодис (секуматик, халдваргүйжлийн спирт)	1 багц	
15	бортого тээвэрлэх тэргэнцэр	1 ширхэг	
Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал			
16	Жижиг өрмийн машин (12мм хүртэлх диаметрэй)	1 ширхэг	
17	Суурин зүлгүүрийн машин (жижиг)	1 ширхэг	
18	Бортогоны савны битүүмжлэл шалгах, бохирдол цэвэрлэх сав 400x600x400мм	1 ширхэг	
19	Төмрийн хөрөө	1 ширхэг	
20	Цахилгаан гагнуур (жижиг)	1 ширхэг	


21	Тохируулагч түлхүүр (газовый)	1 ширхэг	
22	Хавхалганы углуургын (резва) тохируулагч	1 ширхэг	
23	Бахь	1 ширхэг	
24	Таслагч	1 ширхэг	
25	Бахь (нарийн үзүүртэй)	1 ширхэг	
26	Түгжээ тайлагч бахь	1 ширхэг	
27	Төмрийн хайч	1 ширхэг	
28	Алх	1 ширхэг	
29	Төмрийн хуурай	1 ширхэг	

30	Төмрийн цүүц	1 ширхэг	
31	Цоолтуур	1 ширхэг	
32	халивын багц	1 багц	
33	Шөвөг	1 ширхэг	
34	Хавчигч (тиски)	1 ширхэг	
35	Зүлгүүр (өргөн, нарийн)	1 ширхэг	
36	Цавуу	1 ширхэг	
37	Наалддаг тууз	2 ширхэг	

38	Хөвөн	2 ширхэг	
39	Барааны саван	2 ширхэг	
40	Бичгийн хэрэгслийн цавуу	1 ширхэг	
41	Сантехникийн олс	1 ширхэг	
42	Багс (өргөн, нарийн)	2 ширхэг	
Агаар хадгалах сав цэнэглэх өрөө			
43	Агаараар цэнэглэх шахуурга (компрессор) суурин	1 ширхэг	
44	Агаараар цэнэглэх шахуурга (компрессор) зөөврийн	1 ширхэг	
45	Агаар хадгалах сав цэнэглэх үед байрлуулах аюулгүйн хайрцаг	4 ширхэг	

46	Агаарын чанар тодорхойлох багаж	1 ширхэг	
Амьсгалын бие даасан төхөөрөмжийг цэвэрлэх, хатаах өрөө			
47	Амьсгалын бие даасан төхөөрөмжийг угаах төхөөрөмж (АБДТ-ийн засварын төвд байрлуулна)	1 ширхэг	
48	Амьсгалын бие даасан төхөөрөмжийг ариутган хатаах төхөөрөмж (АБДТ-ийн засварын төвд байрлуулна)	1 ширхэг	
49	Угаалтуур	1 ширхэг	
50	Гар хатаагч	1 ширхэг	

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
 1/... дугаар тушаалын 08 дугаар хавсралт
 485



**ШАХСАН АГААРЫН АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН
 ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**


Дүүргэх хийн төрөл		Агаар
Хэрэглэх хугацаа		45-50 минут
Нийт жин		11кг-аас ихгүй (нүүрний хамгаалах баг болон агаарыг тооцохгүйгээр)
Бортого	Материал	Холимог хөнгөн цагаан, карбон, циллойд
	Багтаамж	6.8 литрээс багагүй
	Шахах даралтын дээд хязгаар	300 кг/см ² (29.4 МПа)
	Доторх даралтын хяналтын даралт	500 кг/см ² (49.0 МПа)
	Шахах агаарын хэмжээ	2010 литрээс багагүй
	Жин	4.2 кг-аас ихгүй (хаалтын жин болон агаарыг тооцохгүйгээр)

ЭД АНГИЙН МАТЕРИАЛЫН ТӨРӨЛ

д/д	Шахсан агаарын амьсгалын бие даасан төхөөрөмж	Эд ангийн нэршил	Материал	
1	Нүүрэвч маск	Маск	EPDM rubber	
2		Visor (нүүрэвч маскийн харах хэсэг)	Polycarbonate	
3		Frame (маскийн хүрээ)	Polyetherimide	
4		Head strap (нүүрэвч маскийн толгойн татуурга)	Aramid	
5		Нүүрэвч маскийн чангалуурын төрөл	5-6 чангалууртай	
6		Харах өнцөг	180° градусаас багагүй	
9		Жин	850гр-аас ихгүй	
10		Үүргэвч, бортого	Үүргэвчийн их бие	PA66 + glass fiber
11			Бүсэлхийн бүс	Aramid
12	Бүсэлхийн бүсний түгжээ		Noryl	
13	Агаар хадгалах савны бэхэлгээ		Aramid	
14	Даралт хэмжигч заалтын гадна хүрээ		Silicon(resistance to heat)	
15	Мөрний оосор		Aramid	
16	Жин		2,8кг-аас ихгүй	

Жич: Амьсгалын бие даасан төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг нь Олон Улсын EN136, EN137 class 2, NFPA 1981 стандартуудыг хангасан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
А/... дугаар тушаалын ... дүгээр хавсралт
1485



ТУСГААРЛАГЧ ШҮҮГЧ АГААРЫН АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНГЭЭГЧ, ШҮҮГЧ ШОХОЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Түүний найрлагад идэмхий натри % 4

Нүүрсний хүчил %,4-С ихгүй

Чийглэг %,16-21

Болсон шохой үлдэх хувь

Мөхлөгийн хэмжээ нь 1-6,5 мм хүртэл байх ба тэдгээрийн эзлэх хувь янз бүр
байна.

Үүнд:

-5,5-6,5 мм /илүүгүй/.5

-2,8-5,5 м/илүүгүй/.90

-1-2,8мм /илүүгүй/.5

-1 мм-ээс бага /нунтаг, тоос/ .0-6 илүүгүй тус тус байх шаардлагатай.

Тайлбар: Аврагчдын амь хамгаалах тусгаарлагч шүүгч төхөөрөмжид ашигладаг гол материал бол химийн шингээгч шохой юм. Үүний үүрэг нь нөхөн сэргээх патроноор (сум) дамжих амьсгалаас гарсан хийнээс нүүрсхүчлийн хийг шингээн авч цэвэрлэх явдал мөн. Иймээс химийн шингээгч шохой нь тодорхой шаардлагад зохих стандартад нийцсэн, чанарын үзүүлэлтийг хангасан байх ёстой. Энэ нь мөхлөгжсөн цагаан буюу цагаан саарал өнгийн бодис бөгөөд мөхлөг нь цилиндр хэлбэртэй ойролцоогоор 4 мм орчим диаметртэй байдаг.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
1/185 дугаар тушаалын 10 дугаар хавсралт



ХҮЙТНИЙ УЛИРАЛД ТУСГААРЛАГЧ ШҮҮГЧ ТӨХӨӨРӨМЖТЭЙ АЖИЛЛАХ ХУГАЦАА


Малталт дахь агаарын температур (хасах градусаар)	Малталтад байх хугацаа (минут)	Малталтаар зорч их хөдөлгөөн (минут)	
		Хэвтээ	Налуу
0-5	230	100	75
5-10	180	75	55
10-15	150	65	45
15-20	120	50	35

БИТҮҮМЖЛЭЛ ШАЛГАХ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. Усны баганын даралт хэмжигчийг хэмжих хязгаар 1300+1300 Па хүртэл
2. Усны баганын даралт хэмжигчийг төгсөх нэгж нь.....1 мм/10 Па;
3. Хөвөгч урсгал хэмжигчийг илрүүлэх хүрээ ба нарийвчлал 1
4. Бага урсгал хэмжигч0.05 - 2.5 л/мин, нарийвчлалын анги 2.5
5. Их урсгал хэмжигч 10-100 л/мин, нарийвчлалын анги 1.5
6. Агаарын шахуургын хангамжийн урсгалын хурд8-12 л/мин;
7. Агаарын шахуургын тэжээлийн хангамж хувьсах гүйдлийн хүчдэл.....220в
8. Гадаад хэмжээс.....(Урт × Өргөн × Өндөр) 300 × 190 × 420 мм.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
1485 А. дугаар тушаалын 11 дүгээр хавсралт



ТУСГААРЛАГЧ ШҮҮГЧ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хүчин чадал
1	Ажил гүйцэтгэхэд хамгаалах хугацааны доод хязгаар (цагаар)	4
2	Хүчилтөрөгчийн баллон дахь даралт (атм)	200
3	Бортого дахь хүчилтөрөгчийн нөөц (литр)	440
4	Нөхөн сэргээх патроны шингээгч шохойны жин (килограмм)	2.1
5	Хүчилтөрөгчийн өгөлт (литр, минут) байнгын	1.4-1.8
6	Хүчилтөрөгчийн гараар дүүргэх хурд (литр, минут)	80
7	Хүчилтөрөгчийг автоматаар дүүргэх хурд (литр, минут)	80
8	Илүүдлийн хаалтын онгойх даралт	400Па-аас 700Па хүртэл
9	Амьсгалын хүүдийн ашигтай эзлэхүүн (литр)	5
10	Овор хэмжээ (мм)	470
	-Урт	375
	-Өргөн	190
	-Өндөр	
11	Төхөөрөмжийн нийт жин (килограмм)	12,9

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
1485 дугаар тушаалын 12 дугаар хавсралт



**БИТҮҮМЖЛЭЛ ШАЛГАХ ТӨХӨӨРӨМЖӨӨР ТУСГААРЛАГЧ ШҮҮГЧ
ТӨХӨӨРӨМЖИЙГ ШАЛГАСАН ТУХАЙ БҮРТГЭЛ**

№	Шалгах үзүүлэлтүүд	Усан баганын Түвшин	Уушгины автомат нь сийрэгжилтээр даралт (Усан баганын түшингээр, мм)	Түвшиний илүүдлийн даралт хэмжигч ажиллах даралт (Усан баганын түшингээр, мм)
1	Илүүдэл даралтын үед бин, битүү шалгахад.			
2	Хавхалгаар өгч буй хүчилтөрөгчийн тогтмол өгөлтийн хэмжээ.			
3	Илүүдлийн хавхалга ажиллах даралтыг шалгах усан баганын түшингээр 20+-10.			
4	Уушгины автоматын ажиллах усан баганын түшингээр сийрэгжилтээр Даралт 20+-10.			
5	Даралтын хялгасан хоолой битүүг шалгах.			
6	Дотроос гадагш битүүмжийг шалгах шалгах.			
7	Шүлсний шахуургын ажиллагааг шалгах.			